

Пентатух

1-р Хичээл

Пентатухын Танилцуулга

Эх бичвэр



thirdmill

Biblical Education. For the World. For Free.

© 2014 Гурав Дахь Мянган Үйлчлэл

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр өөрчлөхийг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад зохиогчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Библийн бүх эшлэлийг Ариун Библи 2019 (АБ2019), Ариун Бичээс Нийгэмлэг.

ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ

Гурав дахь мянган үйлчлэл нь 1997 онд үүсгэн байгуулагдсан, ашгийн бус, Христитгэлийн Сайнмэдээний үйлчлэл бөгөөд дараах талбаруудад чиглэдэг:

Библийн Боловсролыг. Бүх дэлхийд. Үнэгүйгээр.

Бидний зорилго бол үйлчлэлд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан, дахин давтагдашгүй, цуврал хичээлүүдийг Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн манай хөтөлбөрүүд хамтран ажилладаг үйлчлэлүүдээр маань дамжуулан өөр олон орны хэл уруу орчуулагдаж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг. Эдгээр нь сургууль, бүлгүүд, хувь хүмүүс танхимаар болон цахимаар ашиглахад зориулагдсан болно.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд боловсруулсан. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид нь теологийн мэргэжлийн сургагч багш нар, орон орны орчуулагч нар маань теологийн мэдлэгтэй зэрэг давуу талтай юм. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж болон арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог билээ.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд Гурав дахь мянган үйлчлэл нь сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг бий болгосоор ирсэн. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчлэл нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (IRS as a 501(c) (3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчлэлийн тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.thirdmill.org цахим хуудсаар зочлоорой.

Гарчиг

Удиртгал	1
ОРЧИН ЦАГИЙН ШҮҮМЖЛЭЛТ ХАНДЛАГУУД.....	1
Таамгууд	2
Натурализм	2
Түүхэн хөгжил.....	3
Бичээч	5
Бурханы нэрс	5
Давхардсан хүүрнэлүүд.....	6
Зөрчилддөг хэсгүүд.....	7
Тайлбарлах стратегиуд.....	8
Эх сурвалжийн шүүмж.....	8
Хэв маягийн шүүмж	9
Уламжлалын шүүмж.....	10
Найруулгын шүүмж.....	10
Орчин цагийн шүүмж.....	11
ОРЧИН ЦАГИЙН ЭВАНГЕЛИЙН ЧИГ ХАНДЛАГУУД.....	11
Таамгууд	12
Сүпернатурализм	12
Түүхэн хөгжил.....	13
Бичээч	14
Библийн нотолгоо	15
Мосег бичээч гэх үндэс	16
Эвнгелист Тайлбарлах стратегиуд	21
Сэдэвчилсэн тайлбар	21
Түүхэн тайлбар.....	22
Утга зохиолын тайлбар.....	23
ДҮГНЭЛТ.....	24
ХАМТРАГЧИД.....	26
ҮГСИЙН ТАЙЛБАР	27

Пентатух

1-р Хичээл

Пентатухын танилцуулга

УДИРТГАЛ

Хэрэв бидэнд Библи байгаагүй бол Христитгэл маань ямар их өөр байх байсан бол гэж та бодож үзсэн үү? Ахлагч нар хойч үедээ заавар захиасаа захиж үлдээх боловч зөв эсэхийг нь шалгах, зөрүүтэй үзэл бодлыг шүүх хэм хэмжээ байхгүй гэсэн үг.

Мосегийн цаг үед амьдарч байсан хүмүүс яг ийм нөхцөлд байсан нь лавтай. Тэдэнд үе уламжлан ирсэн өнө эртний болон өвгөдийнх нь түүх л байсан. Тэд Бурхан Израилыг хэрхэн Египетээс авран гэтэлгэж, хуулиа өгч, амлагдсан нутагт хөтлөн хүргэсэн тухай сонсож өссөн. Гэвч тэд Бурхан тухайн цаг үед нь Израилд юу хийж байгаа, ирээдүйд юу хийх тухай юунд итгэж байв? Мөн тэд өөр өөр үзэл санааг хэрхэн шүүх байсан бэ? Харин Бурхан тэдэнд итгэлийн хэм хэмжээ болгон бидний өнөөгийн хэлж заншсанаар Пентатух буюу Библийн эхний таван номыг өгсөн. Тийнхүү тэдгээр бүх асуултад нь хариулт өгч чадсан юм.

Энэ бол Пентатух хэмээх цуврал хичээлийн маань эхний хичээл бөгөөд энэхүү хичээлийн нэр бол “Пентатухын танилцуулга” юм. Энэ хичээлээр бид Израилын итгэлийн хэм хэмжээ болсон Эхлэлээс Дэд Хууль хүртэлх Библийн номуудын тухай танилцуулах болно.

Пентатухын тухай танилцуулга маань хоёр гол хэсэгт хуваагдаж байгаа. Нэгдүгээрт, бид Библийн яг энэ хэсгийн талаарх орчин цагийн шүүмжлэлт хандлагыг тайлбарлана. Өөрөөр хэлбэл Бичвэрийн бүрэн эрх мэдлийг үгүйсгэдэг тайлбарлагч нарын үзэл бодлыг төлөөлдөг хандлагуудын тухай үзэх юм. Харин дараа нь бид Библийг Бурханы онгодоор бичигдсэн үг учраас бүрэн эрх мэдэлтэй гэж хүлээн зөвшөөрдөг орчин цагийн эвангелийн үзэл харааны тухай авч үзнэ. Ингээд эхлээд Пентатухын талаарх орчин цагийн шүүмжлэлт хандлагын тухай авч үзье.

ОРЧИН ЦАГИЙН ШҮҮМЖЛЭЛТ ХАНДЛАГУУД

Хэдийгээр хичээлүүд маань өөр зүйлийг авч үзэх боловч орчин цагийн Библийн судлаачдын олонх нь биш ч, цөөнгүй хэсэг нь Пентатухын бурханлаг онгод болон эрх мэдлийг үгүйсгэж байсныг ойлгох нь чухал. Тэд мөн Пентатух нь Израилд хуулийг дамжуулан өгсөн Мосегийн үеэс гаралтай гэдэг уламжлалт Иудейн болон Христитгэлийн үзлийг ч үгүйсгэсэн. Олон олон Библийн тайлбарлагчид, багш нар, пасторууд болон энгийн хүмүүс ч хүртэл энэ үзлийг хүлээн зөвшөөрч байлаа. Тиймээс Бичвэр судалдаг хашир оюутнууд уг үзлийг анзаарахгүй өнгөрөх боломжгүй байдаг. Тиймээс бид шүүмжлэлт эрдэмтэд Библийн энэ хэсгийн талаар ямар үзэлтэй байсан тухай ойлголттой байх нь нэн чухал.

Сүүлийн 150-200 жилийн хугацаанд шүүмжлэлт эрдэмтэд Пентатухыг судлахад маш их анхаарал хандуулсан. Эвангелийг баримтлагч бидний хувьд тэдний үзэлтэй санал нийлэхгүй олон зүйл бий хэдий ч Хуучин Гэрээний тэдгээр олон судлаачид чухам юуг хэрхэн тайлбарлаж байгааг сайн мэдэж байж зөв хариулт өгч чадна. Бид эргэн тойронд маань болж байгаа зүйлсийг үл анзааран Библийг өмнөх шигээ вакум орчинд судалж болохгүй. Мөн бид өөрсдийн бодлыг хэлэхийн өмнө бусад хүмүүс ямар бодолтой байгааг мэдэж байх нь чухал шүү дээ.

— Др. Жон Освалт

Пентатухын талаарх орчин цагийн шүүмжлэлт хандлагыг ойлгохын тулд бид гурван асуудлыг авч үзэх болно. Эхнийх нь, шүүмжлэлт үзэлд нөлөөлсөн зарим чухал таамаглалууд. Хоёрт, Пентатухын бичээчийн эрх мэдлийн талаарх шүүмжлэлт хандлагууд. Гуравт, шүүмжлэлт эрдэмтдийн баримталдаг тайлал хийх чухал стратегиуд. Тэгэхээр эхлээд тэдгээр хандлагуудад ихээхэн нөлөө үзүүлж байсан зарим урьдач таамгуудын тухай үзье.

ТААМГУУД

Ихэнх тохиолдолд Библийн энэ хэсгийн талаарх орчин цагийн шүүмжлэлт үзэл хараа нь 17-18-р зууны үеийн Баруун Европын Соён гэгээрлийн үеийн оюуны үзэл санаанаас шууд урган гарсан байдаг.

Хичээлийнхээ зорилгын хүрээнд бид Соён гэгээрлийн үеэс урган гарсан хоёр гол таамгийг авч үзэх болно. Энэ хоёр таамаг нь Пентатухын шүүмжлэлт тайлбарт ихээхэн нөлөөлсөн байдаг. Нэгдүгээрт, бид натурализмын тухай ойлголтыг үзнэ. Хоёрдугаарт, Израилын итгэл үнэмшлийн түүхэн хөгжлийн талаарх таамгуудыг авч үзэх болно. Ингээд натурализмын тухай эхлээд үзэцгээе.

Натурализм

Товчхондоо, Соён гэгээрлийн натурализм бол сүнслэг бодит зүйлс үнэхээр оршин байсан ч үзэгдэх дэлхий ертөнцөд нөлөө үзүүлээгүй гэдэгт итгэдэг тухайн үеийн томоохон онол байсан юм. Үүнээсээ болж натурализм нь шинжлэх ухааны судалгаанд ямар ч байр суурьгүй байсан. Харин 19-р зууны дунд үеэс Христитгэлийг оролцуулаад Барууны орнуудын шинжлэх ухааны талбар бүрийг ноёрхох болсон байна. Натурализмын Библид судлалд үзүүлсэн гол нөлөө нь нэр хүндтэй судлаачид Пентатухыг Бурханы онгодоор бичсэн гэж үздэг урт удаан түүхтэй Иудейн болон Христитгэлийн итгэлийг үгүйсгэх болсон явдал юм. Үүнээс ч болж ихэнх хүмүүс эртний соёлоос улбаатай шашны бичээсүүдэд ерөнхийд нь хэрхэн ханддаг шигээ л Пентатухт хандах болсон байна. Энэ үзлийн дагуу Пентатух бол зөвхөн хүний

бичсэн бусад төрөл номуудтай л адил төрөл бүрийн алдаа, зөрчлүүд, тэр ч бүү хэл хуурамч теологи, түүхийн санаатай гуйвуулгаар дүүрэн гэж үздэг..

Натурализм руу хөтөлсөн таамгуудаас болж судлаачид Пентатухын онгод болон эрх мэдлийг үл тоох эрх чөлөөг өгөөд зогсохгүй, Израилын итгэлийн түүхэн хөгжлийн талаар мөн тодорхой үзэл баримтлалтай болгосон юм.

Түүхэн Хөгжил

19-р зууны эхээр натурализмаас бидний хэлдгээр “натуралист түүхч үзэл” бий болсон. Энэ нь аливаа зүйлийг ойлгох хамгийн сайн арга зам бол цаг хугацааны туршид эдгээр нь байгалийн жамаар хэрхэн хөгжиж ирснийг нь ойлгох явдал гэж үздэг итгэл үнэмшил юм. 19-р зууны эхээр биологичид газар дэлхий дээр амьдрал хэрхэн бий болж, олон мянганы туршид хэрхэн хувьсан өөрчлөгдөж ирснийг ойлгохыг хичээж байсан гэж болно. Хэл зүйчид хүн төрөлхтний хэлнүүдийн түүхэн хөгжлийг судалж, археологичид эртний хотуудын туурийг сэргээн, хүний нийгмийн хөгжлийг тодорхойлохыг оролдож байлаа. Харин шашин судлалын салбарын судлаачид дэлхийн шашнуудын натуралист ба түүхэн хувьсал өөрчлөлтийг тайлбарлахад гол анхаарлаа хандуулж байсан.

Ерөнхийд нь авч үзвэл, барууны анхны судлаачид дэлхийн шашнуудын хувьсал хөгжлийг тодорхойлохдоо хүн төрөлхтний нийгмийн хөгжлийн тухай ойлголттойгоо адилтган авч үзсэн байдаг. Жишээ нь, эртний хүмүүсийн байгуулсан анхны овог аймгийн нийгэм нь байгалийн биет зүйл бүр сүнстэй холбоотой гэдэгт итгэдэг анимизмыг дагадаг байсан. Цаг хугацаа өнгөрөхөд эртний овог аймгуудаас олон бурханд итгэдэг политейзм бүхий арай томоохон овог аймгууд бий болсон. Томоохон овог аймгууд нэгдэн холбоот улсыг байгуулах үед политейзмаас хенотейзм буюу аль нэг бурхан нь бусдаасаа илүү агуу гэсэн үзэл уруу шилжсэн байна. Харин хожим нь хаант улсууд, эзэнт гүрнүүд бий болох үед хүчирхэг язгууртнууд болон санваартнууд улс орноо хенотейзмээс монотейзм буюу цорын ганц бурханд итгэх итгэл уруу хөтлөн дагуулсан гэж тэд үздэг байсан. Тэдний энэхүү түүхэн натуралист үзлээр бол өндөр хөгжил бүхий энэ үе хүртэл шашны хэм хэмжээг тогтоогоогүй эсвэл бичгээр буулгаагүй байсан. Харин энэ үеийг хүртэл шашин зөвхөн аман болон зан үйлийн уламжлал хэлбэрээр л үеэс үед дамжин ирсэн гэж үздэг байв.

Гэхдээ хожим 20-р зууны сүүлээр антропологичид шашнууд ийм энгийн байдлаар хөгжиж ирсэн гэдэг үзлийг ихээхэн үгүйсгэж байсныг тэмдэглэх нь зүйтэй. Библийн судлаачид орчин цагийн эхэнд Пентатухт хандаж байсан хандлагад нөлөөлсөн гэж хэлж болно. Өнөөдөр ч Библийн судалгаанд тэдний энэ хандлага нөлөөлсөөр байна.

Бидний хэлж заншсанаар “шүүмжлэлт судалгаа” нь ерөнхийдөө Хуучин Гэрээг өнө эртний, боловсронгуй бус итгэл үнэмшлээс илүү нарийн цогц, боловсронгуй шашин болон хөгжсөн хөгжлийг тусгасан гэж үздэг. Өөрөөр хэлбэл сүүлийнх нь өмнөхөөсөө илүү

гэж үздэг гэсэн үг. Үүний талаар бид хэдэн тайлбар хийж болох юм. Нэгдүгээрт, эергээр хэлэхэд, Бурхан Өөрийгөө илчлэхдээ тодорхой үе шаттайгаар илчилсэн нь үнэн. Библид Бурханы талаарх онол номлол, ойлголтууд нь өчүүхэн үрээс өсөн хөгжсөн “органик хөгжлийн” тухай харуулдаг. Тэгэхээр Библи өөрөө сургаал номлол нь өсөж хөгждөг болохыг өгүүлдэг. Тэгэхээр, тиймээ, Библид бас Пентатухт ахиц хөгжлийн хэлбэр бий. Бурханы анхны илчлэлүүдээс эхлэн бүрэн биеллээ олох хүртэлх зураглалыг өгдөг. Яг л цэцэг дэлгэрэн ургаж байгааг хурдасган харуулсан зурагтай адил гэж төсөөлж болох юм. Харин хоёрдугаарт, сөргөөр хэлэхэд, шүүмжлэлт судлаачид хүн төрөлхтний түүхийн хувьслын буюу хөгжлийн үзлийг баримталдаг. Энэ нь ахиц дэвшил зайлшгүй байх ёстой гэж үздэг... Тэгвэл бидний хийх ёстой зүйл бол дэлхий ертөнцийг хараад ахиц дэвшил зайлшгүй байдаг гэдэг нь агуу үлгэр домог төдий гэдгийг ойлгох явдал юм. Тиймээ бид өсөж хөгждөг, бас хөгжих тусам өөрчлөгддөг. Тэгэхээр, хуучин, эртний зүйлсийг дорд муу гэж үздэг орчин цагийн бардамнал нь гүн ухааны таамаг төдий бөгөөд Библид огт байдаггүй ойлголт юм шүү дээ. — Рев. Майкл Ж. Глодо

Дэлхий шашнуудын талаарх орчин цагийн үзэл хараа нь Израилын итгэл бишрэлийн хөгжлийн талаарх Библийн дүрслэлээс эрс ялгаатай байдаг. Пентатухт Израилын итгэл үнэмшлийг үргэлжид монотейст байсан гэж харуулдаг. Адам Евагаас эхлэн Ноа, итгэлийн эцгүүд, Израилын овгуудын ахлагчид итгэмжтэйгээр цорын ганц үнэн Бурханыг бүхнийг Бүтээгч хэмээн хүндлэн дээдэлсээр ирсэн. Энэ монотейст итгэл бүр анхнаасаа л аман болон зан үйлийн уламжлал хэлбэрээр дараа дараачийн үеэс үед дамжин ирснийг бид Эхлэл номоос хардаг шүү дээ.

Харин хожим нь Мосегийн үед шийдвэрлэх өөрчлөлт шинэчлэлт гарсныг бид Пентатухаас хардаг. Энэ үед Израилын итгэлийг хуульчлан тогтоож эхэлсэн. Мосе Израилын ард түмнийг улс үндэстэн болгон бэлтгэхдээ эхлээд Бурханы хууль ба арван тушаалыг Гэрээний номд бичсэн байдаг. Энэ талаар бид дараа дэлгэрэнгүй үзнэ. Тэгээд мөн Израилын итгэлийг хөтлөн чиглүүлэхийн тулд Пентатухын номуудыг бичсэн. Тиймээс Библийн дагуу бол Израил хаантай бас сүмтэй болохоос бүр өмнө эрт дээр Мосегийн үеэс эхлэн ариун бичээсүүдэд төвлөрч эхэлсэн байгаа юм.

Библийн баримт ийм ил тодорхой байхад л орчин цагийн шүүмжлэлт үзэл нь натуралист түүхч таамгуудаасаа болж энэхүү Библийн түүхэн цаг хугацааны дараалал байх боломжгүй гэж үздэг. Орчин цагийн шүүмжлэлт эрдэмтэд Библид харуулсан Израилын итгэлийн замналыг үгүйсгэдэг. Тэгээд өнө эртний шашнууд хэрхэн хувьсан хөгжсөн тухай орчин цагийн ойлголтдоо нийцүүлэн тодорхойлсон байдаг. Тэдний үзлээр бол Израилын эртний өвөг эцгүүд овгийн анимизм буюу бүх зүйлс сүнстэй гэж итгэн сүсэглэж байгаад дараа нь итгэлийн өвөг эцгүүд буюу овог аймгууд нь өсөн тэлэхийн хэрээр политейзм буюу олон бурхдад итгэх итгэлд шилжсэн гэж үздэг. Мөн энэ үзлийн дагуу Мосе Израилыг Египетээс удирдан гаргасны дараа, түүний удирдаж байсан Израилчууд хенотейзмыг буюу олон бурхдаас нэгийг нь онцлон шүтдэг байсан гэж үздэг гэсэн үг. Тэгээд шүүмжлэлт

тайлбарлагчид яг Бичвэрийн эсрэг буюу нийгмийн хөгжлийн энэ үе шатанд хэн ч байсан Израилын итгэлийн хэм хэмжээг бичгээр буулгах боломжгүй байсан гэж итгэдэг. Энэ мэт бичигдсэн итгэлийн жишиг хэмжээ нь зөвхөн Израилын хаан болон санваартнууд Израилын итгэлийг журамлан цэгцлэхээр зорьж байсан үед буюу Израилын хаант засаг тогтсоны дараа л боломжтой болсон байх ёстой гэж тэд үздэг. Тэгэхээр шүүмжлэлт эрдэмтдийн үзлийн дагуу зөвхөн Израилын хаант улсын үед л ном судар дээрх шашин бий болох боломжтой гэсэн үг.

За, бүгдээрээ Бичвэрийн талаарх орчин цагийн шүүмжлэлт хандлагын таамгуудын тухай болон Израилын итгэлийн түүхэн хөгжлийн тухай үзлээ. Харин одоо бид үүнтэй холбоотой хоёр дахь асуудлыг авч үзье. Эдгээр үзлүүд нь Пентатухын бичээчийн талаарх шүүмжлэлт хандлагад хэрхэн нөлөөлсөн бэ?

Бичээч

Бид шүүмжлэлт тайлбарлагчид нь Израилчуудын итгэл үнэмшил нь Израилын хаант засгийн үед л загварчлагдан бичигдсэн байх боломжтой гэж итгэдэг тухай сая ярилцсан. Мэдээж энэ таамгаар бол Пентатухыг бичихэд Мосе огт оролцоогүй гэж итгэдэг гэсэн үг шүү дээ. Харин тэд эдгээр номууд нь эртний аман хэлбэрээр залгамжлан ирсэн уламжлалыг хаант засгийн үед янз бүрийн хэлбэрээр бичиж буулгах урт удаан үйл явцын дүнд бий болсон гэж үздэг. Тэд эдгээр баримтуудыг Израилын цөллөгийн үеэр болон цөллөгийн дараа засварлаж, Пентатухын номуудыг эмхэтгэн, өнөөгийн бидний мэдэх хувилбарыг гаргасан гэж үздэг. Тэгэхээр Бичвэрийг судалж буй оюутнууд Пентатухын хөгжлийн талаарх энэхүү урт удаан явц бүхий түүхэнд олон судлаач итгэдэг гэдгийг анх сонсоод ямар нотлох баримт байгааг гайхаж хоцордог.

Тэгэхээр бүгдээрээ Пентатухын бичээчийн талаарх энэ хандлагыг авч үзэхдээ шүүмжлэлт судлаачдын ашигладаг гурван гол нотолгоог товчхон харцгаая. Эхлээд Пентатух дахь Бурханы олон янзын нэрсийг авч үзэцгээе.

Бурханы нэрс

Эхэн үеийн шүүмжлэлт тайлбарлагчид Пентатухт Бурханы олон янзын нэр байдгийг анзаарсан байдаг. Эдгээр олон янзын нэрс нь Израилын итгэлийн урт удаан хувьслын замналын баталгаа гэж тэд маргадаг. Жишээ нь, зарим тохиолдолд Пентатухт אֱלֹהִים (Элохим) буюу “Бурхан” гэдэг нэрийг ашигласан байдаг. Зарим тохиолдолд Бурханыг יהוה (Яавэ) буюу “Эзэн” гэж дуудсан байдаг. Пентатухд Бурханы хоёр нэрийг хамтад нь ашиглан тодорхойлсон байдаг. Жишээ нь, “Яавэ Элохим” буюу “Эзэн Бурхан”, “Яавэ Ирэ” буюу “Эзэн хангадаг”, мөн “Эл Элион” буюу “Хамгийн Дээд Бурхан”, “Эл Шаддай” буюу орчуулбал “Агуу Хүчит Бурхан” зэргээр нэрлэсэн байдаг.

Гэхдээ Пентатухт Бурханыг олон янзаар нэрлэсэн нь тийм ч онцгой зүйл биш байсан гэдгийг хэлэх нь чухал. Эртний Ойрх дорнодын бусад шашнуудын бурхдын

нэрсийн тухай хорьдугаар зуунд хийсэн судалгаанаас харахад бусад шашнуудыг бичиж тэмдэглэсэн бичээчид хүртэл бурхдаа олон янзын нэрээр нэрлэсэн байдаг. Тэгсэн ч эхэн үеийн шүүмжлэлт судлаачид Пентатух дахь Бурханы нэрс нь энэ ном урт удаан хугацаанд бичигдсэн гэдгийг илчилж байна хэмээн үзсэн. Зохиолч бүр нэг нэг өөр нэр нэмж бичсээр байгаад Пентатухт Бурхан олон өөр нэрээр бичигдсэн гэж тэд итгэдэг.

Хуучин Гэрээг уншаад та тэр даруй л Бурханыг өөр өөр нэрээр нэрлэснийг анзаарна. Эхлэл 1-р бүлэгт Бурханыг Элохим гэж нэрлэсэн байдаг. Гэтэл Эхлэл 2-р бүлэгт гэнэт л Яавэ гэдэг нэр гараад ирдэг. Шүүмжлэлт хандлага үүнийг эвангелийн хандлагаас тун өөрөөр ойлгодог. Шүүмжлэлт судлаач бол эдгээр нэрсийг өөр өөр хүмүүс бичсэн гэж үзнэ. Харин эвангелийн итгэгч болохынхоо хувьд бид түр азнаж, илүү том зургийг харах хэрэгтэй гэж би бодож байна. Бурхан бол Элохим, тэр бас Яавэ. Элохим гэдэг нь энэ дэлхийг захирагч, Бүтээгч, бүх үндэстнээс агуу хүчирхэг, туйлын төгс Нэгэн, Агуу Хүчит Бурхан гэсэн утгатай. Гэхдээ Израилтай гэрээний харилцаатай болсныхоо дараа Бурхан Өөрийгөө Яавэ гэж илчлэн танилцуулсан байдаг. Тэр бол ард түмнийхээ төлөө байх бас хамт байх “Би байдаг” Бурхан юм. Тиймээс ч Израил бол Бурханы сонгосон ард түмэн учраас Түүний энэ алдар нь гэрээний нэр болох учиртай байжээ.

— Др. Давид Талли

Пентатухыг хэн бичсэн талаарх үзлээ батлахын тулд шүүмжлэлт эрдэмтэд Бурханы олон янзын нэрнээс гадна “давхардсан хүүрнэл” гэж нэрлэдэг зүйлийг танилцуулдаг.

Давхардсан хүүрнэл

Пентатух дахь цөөнгүй багц эшлэлүүд хоорондоо ижил төстэй гэдгийг харахад л ойлгомжтой байдаг. Харин шүүмжлэлт тайлбарлагчид эдгээр багц эшлэлүүд янз бүрийн бүлэг хүмүүсийн өөр өөр аман уламжлалуудаас гаралтай гэдэг. Тэгээд тэдгээр хүүрнэлүүд бий болох явц нь Пентатухт бичигдэн үлдсэн гэж үздэг.

Жишээ нь, тэдний хэлдгээр Эхлэл 1:1-2:3 болон Эхлэл 2:4-25 дээрх “бүтээлийн хоёр хүүрнэл”-ийг тэд ихэнхдээ онцлон ярьдаг. Мөн тэд Эхлэл 12:10-20; 20:1-18; мөн 26:7-11 дээрх Абрахам болон Исаак хоёрын аль аль нь худал хэлж, эхнэрүүд нь аюулд орсон тухай хүүрнэлүүдийн ижил төстэй талыг онцлон ярьдаг. Уул нь Иудей болон Христитгэлт тайлбарлагчдын аль аль нь эдгээр төсөөтэй талуудыг тун үндэслэлтэйгээр тайлбарласан байдаг шүү дээ. Харин шүүмжлэлт эрдэмтэд эдгээр хүүрнэлүүд нь өөр өөр аман уламжлалуудын тэмдэглэл бөгөөд хожим нь Пентатухт багтсан гэдэг үзлийг л ягштал баримталдаг.

Гуравдугаарт, шүүмжлэлт судлаачид Пентатух дахь зөрчилтэй хүүрнэлүүдийн тухай ярьдаг. Тэдгээр зөрчилтэй хүүрнэлүүд нь Библийн энэ хэсгийг хэн бичсэн тухай тэдний нарийн төвөгтэй шинэ онолуудад дэмжлэг болох нь бий.

Зөрчилддөг хэсгүүд

Жишээ нь, тэд ихэнхдээ Гэтлэл 12:1-20 болон Дэд хууль 16:1-82 дээрх Дээгүүр өнгөрөх баярын зааврыг ялгаатай байдлыг дурдсан байдаг. Мөн тэд Гэтлэл 20:1-17 болон Дэд Хууль 5:6-21 дээрх Арван тушаалын ялгаатай талуудыг онцолдог. Үнэндээ уламжлалт Иудейн болон Христитгэлийн тайлбарлагчид эдгээр ялгаатай талуудын учрыг хэрхэн олж болохыг аль хэдийн заачихсан шүү дээ. Гэтэл шүүмжлэлт тайлбарлагчид эдгээр ялгаатай талуудыг аман уламжлал, бичгийн эх сурвалжуудын урт удаан, нарийн төвөгтэй түүхийн тусгал гэж үзээд өнөөгийн бидэнд байгаа Пентатух бол үүний үр дүн юм гэдэг.

Библийг унших үед, ялангуяа Пентатухыг унших үед, уран зохиолын олон өөр төрөлтэй бид тааралддаг шүү дээ. Зарим тохиолдолд, жишээ нь, Эхлэл номын эхэн хэсэгт, Эхлэл 1:1–2:3-р эшлэлүүдэд... Бурхан тодорхой дарааллаар долоон өдрийн турш бүтээж байгаа дүр зургийг хардаг. Бурхан үгээрээ бүтээсэн ба Бурханы хүчирхэг байдлын тухай, Бурхан бол Бүтээгч гэдэг тухай, Бурхан хүн төрөлхтнийг өөрийн дүр төрхийн дагуу бүтээсэн тухай өгүүлдэг. Үүний яг дараагийн бүлэгт буюу 2:4-25-р эшлэлд бүтээлийн тухай өөр нэг түүх бий. Энэ түүхэнд Бурханыг Бурхан Эзэн гэж дуудсан байдаг учраас зарим хүмүүст зөрчилтэй санагддаг. Юмсыг бий болгохын тулд үгээ хэлдэг Бурхан одоо хүнийг бүтээх гэж доош бууж ирсэн байгаа тухай гарч байна. Тэрээр хүнийг, анхны хүнийг газар шорооноос бүтээсэн гэжээ. Тэгээд эрэгтэй хүнээс анхны эмэгтэйг бүтээсэн. Тэгэхээр Бурхан үл үзэгдэгч бүтээгч Бурхан байхын оронд, газар дэлхий дээр бууж ирээд Өөрийн гараар хүнийг бүтээсэн байгааг харж байна уу... Тиймээс үнэндээ ийнхүү өөр түүх байгаа нь нөгөөтэйгөө зөрчилддөггүй харин ч илүү бүрэн гүйцэт болгодог... Тиймээс энд үнэхээр зөрчилтэй агуулга байгаа юм бол эртний хүмүүс олж харахгүй байсан гэж үү гэдгийг бид санах хэрэгтэй. Энэ л гол түлхүүр нь шүү дээ. Тэд тэнэг хүмүүс байгаагүй нь лавтай. Өөр цаг үе, өөр соёл нийгэмд байсан хэдий ч бидэнтэй л адил оюун ухаантай байсан. Тиймээс эдгээрийг хамтад нь байлгасаар ирсэн нь тэдний мэргэн ухаан байсан юм. Хоёр дахь түүх нь бидэнд илүү их гар бие оролцдог Бурханы тухай өгүүлдэг. Бид үүнийг теологид угаасаа байсан Бурхан буюу бүтээлд орж ирсэн Бурхан гэж хэлдэг...Бичвэрийг итгэмжтэйгээр уншина гэдэг бол хардаж сэжиглэх биш харин ойлгож мэдэхийн тулд уншихыг хэлдэг. Юу гэвэл, надад асуулт байж болно. Гэхдээ энэ нь итгэлийг эрж ойлгохын төлөө байх ёстой. Эцэст нь би Библид байгаа зүйлс нь Бурхан байлгахыг хүссэн учраас л бичигдсэн гэдэгт итгэдэг. Уншигчийн хувьд би маш анхааралтай унших ёстой. Ялангуяа ойлгомжгүй зүйлтэй тулгарвал Бурхан хоёр өөр зүйлийг энд хамтад нь оруулснаараа юу хэлэх гэсэн юм бол гэдгийг ойлгохыг хичээнэ гэсэн үг. Үнэндээ өөр газарт, өөр цаг хугацаанд байгаа

хоёр өөр дүр зураг илүү их зүйлсийг ойлгуулж чадах учраас бид харин ч талархах хэрэгтэй.

— Др. Брайн Д. Рассэл

Ингээд орчин цагийн шүүмжлэлт хандлагын таамгууд, бичээчийн талаарх үзэл баримтлалуудыг авч үзлээ. Одоо тэгэхээр шүүмжлэлт судлаачдын Пентатухыг судлахдаа баримталдаг тайлбарлах гол стратегиудыг үзэж болохоор боллоо.

ТАЙЛЛЫН СТРАТЕГИ

Эдгээр асуудлуудыг хураангуйлан тайлбарлах олон арга байдаг ч бид орчин цагийн шүүмжлэлт судлаачдын тайлбарлах таван гол стратегийн тухай үзэх болно. Тэгэхдээ бид тэдгээр стратегийг эх сурвалжаас нь эхлээд хөгжиж ирсэн дарааллаар нь авч үзнэ.

Эх сурвалжийн шүүмж

Анх “Утга зохиолын шүүмж” гэгддэг байсан эх сурвалжийн шүүмж нь К.Х. Графын 1866 онд хэвлэгдсэн “*Хуучин Гэрээний Түүхийн номууд*” нэртэй зохиолд анх дурдагдсан байдаг. Тэгээд олонд танигдсан орчуулагч Жулиус Веллхаусений 1883 онд хэвлэгдсэн “*Израилын Түүхийн Урьдач Дүгнэлт*” хэмээх номд боловсронгуй болсон байдаг.

Эх сурвалжийн шүүмжүүд нь Пентатух нь эртний шашны бичээсүүдтэй л адил аман уламжлалаас гаралтай гэж итгэдэг байсан. Гэхдээ тэд Пентатухыг Израилын хаант засгийн үеэс гаралтай бие даасан бичгийн эх сурвалжуудаас үүсэлтэй гэж итгэдэг байв. Тэгээд үүнийг тайлбарлаж, тодорхойлоход бүхий л анхаарлаа төвлөрүүлсэн.

Эртний хаант засаглалын үед бичигдсэн Пентатухын хамгийн эртний эх сурвалжийн баримтыг Веллхаусений нэр томъёоны дагуу Явист буюу “Ж” үсгээр товчилдог. Энэ нь бичигдсэн эх сурвалжид Бурханы хамгийн түгээмэл нэр болох Явэг Герман хэлэнд “Ж” үсгээр эхэлж бичигдсэн байдгаас улбаатай. Энэ нь Англи хэлэнд “Жехова” гэж хэлдэгтэй адил юм. “Ж” сурвалж буюу Явэгийн талаарх эшлэлүүд Эхлэл болон Гэтлэл номд олон байдаг. Эх сурвалжийн шүүмжлэгчид Пентатухын энэ хэсгүүд Христээс өмнөх 950 онд, Соломоны үед Иудейд бичигдсэн гэж маргадаг. Энэ үзлээр “Ж” сурвалж нь эртний цаг үеийн тухай өгүүлсэн баримт бичгийг төлөөлдөг бөгөөд Израилын шашны хууль дүрэм ба төвлөрөл, мөн Йерусалим дахь Давидын хаант засгийн нийгмийг дэмждэг баримт бичиг юм.

Пентатухын бичгийн хоёр дахь эх сурвалжийг Элохист буюу “Э” сурвалж гэж үздэг. Учир нь тэдгээр хэсгүүдэд Бурханыг Элохим гэж нэрлэсэн байдаг. “Э” сурвалж нь Эхлэл болон Гэтлэл номуудад бас байдаг. Энэ онолын дагуу “Э” сурвалж нь Израил улс хоёр хаант улс болон задарсны дараа буюу Христээс Өмнөх 850 оны

үед Хойд хаант улсад бичигдсэн гэж үздэг. Энэхүү “Э” сурвалж нь Давидын хаант угсааг шүүмжилдэг хойд зүгийн эш үзүүлэгийн үзэл санааг дэмжсэн байдаг.

Утга зохиолын гурав дахь эх сурвалжийг “Д” буюу Дэд Хуулийн сурвалж гэж нэрлэдэг. “Д” сурвалжийн эшлэлүүд нь голчлон Дэд Хууль номд орсон байдаг ба Пентатухын бусад номуудад тун цөөхөн байдаг тул ийнхүү нэрлэжээ. Энэ төрлийн эх сурвалжууд нь ойролцоогоор Христээс өмнөх 622 оны Иосиа хааны шинэчлэлээс Христээс Өмнөх 586 оны Вавилончуудад цөлөгдсөн Йерусалимын уналтын хоорондох хугацаанд ихэвчлэн хамаардаг. Нэг түгээмэл таамгаар бол “Д” сурвалж нь хойд Израилаас салж Иудатай нийлсэн Левичүүдийн үйл хэргийг харуулдаг байна. Левичүүд Давидын удамд үнэнч байсан ч бас ихээхэн шүүмжлэлтэй ханддаг байсан юм.

Төгсгөлд нь Пентатухын хөгжил дэх сүүлийн буюу дөрөв дэх гол утга зохиолын эх сурвалжийг ерөнхийдөө “П” сурвалж гэдэг. Энэ нь приест буюу тахилч гаралтай бичээч ба бичээчдийг илэрхийлдэг. Нийтлэг таамгаар бол “П” нь Христээс өмнөх 500-400 оны хооронд Левит номыг бичиж, Пентатухын зарим хэсгүүдийг эмхэтгэн засварласан хэсэг бүлэг тахилч нар байсан гэж үздэг. Энэхүү шинэчлэгдсэн ойлголтын дагуу бол “П” сурвалж нь Пентатухыг цөллөгөөс буцаж ирсний дараах Израилчуудын нийгмийн байр суурь болон мөргөл хүндлэлийг сэргээн чиглүүлэхэд зориулан загварчилсан гэж үздэг.

Тэгэхээр хорьдугаар зууны үед чадварлаг эрдэмтэд эх сурвалжийн шүүмжийн нэгийг нь ч үл хайхарч орхигдуулаагүй. Харин ч эдгээр үзэл санааны ул мөр Пентатухын талаарх шүүмжлэлт саналуудад одоо ч үзэгдсээр байдаг. .

Хэв маягийн шүүмж

Пентатухын талаарх шүүмжлэлт хандлагын хоёр дахь гол стратегийг “хэв маягийн шүүмж” гэж үзсээр ирсэн.

Хэв маягийн шүүмж нь анх Херманн Гюнкелийн 1901 онд бичигдсэн “Эхлэл номын домгууд” хэмээх ажлаар Хуучин Гэрээний судлалын тусгай салбар болж эхэлсэн. Гюнкел болон түүнийг дагагчид эх сурвалжийн шүүмжийн гол итгэл үнэмшлийг хүлээн зөвшөөрч байсан. Гэхдээ Пентатухын хөгжлийн эхэн үеийн талуудад илүүтэй анхаарсан. Хэв маягийн шүүмжлэгчид нь Пентатухын бичгийн эх сурвалжуудад анхаарал хандуулахаас илүү Израилын хаадын өмнөх үеэс өмнөх аман уламжлал гэж итгэж байсан зүйлдээ илүүтэй анхаарч байсан юм.

Хэв маягийн шүүмжлэл олны дунд ид түгэн дэлгэрч байсан тэр үед судлаачид бичиг үсэг тайлагдаагүй овгийн нийгэм соёлд аман уламжлалууд ямар үүрэг гүйцэтгэж байсныг тэмдэглэсэн байдаг. Хэв маягийн шүүмжлэгчид Пентатухын баримтад эх сурвалжууд руу хөтлөх жинхэнэ, динамик, бичиг үсэггүй үеийн уламжлалуудыг эрэн хайж байхдаа эдгээр судалгааг хийсэн байдаг.

Хэв маягийн шүүмж нь ерөнхийдөө хоёр талт арга барилтай байсан. Нэг талаар, хэв маягийн шүүмжлэгчид домог, үлгэр, туульс, хайр сэтгэлийн түүхүүд, баатрууд болон сургаалт зүйрлэл гэх мэт эртний аман уламжлалын хэлбэр, төрлүүдийг олохын тулд бичээсийн хэсгийг задлан шинжилдэг байсан. Харин нөгөө талаараа тэд тэдгээр төрлүүдийг аман уламжлалуудын “Сизе айм либэн” (Sitze im Leben) буюу “амьдралын нөхцөл байдал” гэх нийгэм соёлын нөхцөлтэй нь уялдуулан

судалдаг байсан. Үүнд магтаал хүндлэл, овгийн суурьшил, өрхийн зохион байгуулалт, тухайн нутгийн хууль шүүх гэх мэт зүйлс багтдаг.

Жишээ нь, Эхлэл номын 32:22-32-р эшлэл дэх Иаков Пениелд барилдсан түүхийг эртний овгуудын гал тойрон сууж ярьдаг байсан домгоос гаралтай гэж үздэг шүүмжлэгчид цөөнгүй байдаг. Тэд үүнийг Иаббок голын эрэг дээр болсон ер бусын, ид шидийн үйл явдлуудын тухай үлгэр домгуудаас гаралтай гэж үздэг. Энэ онолын дагуу бол харин энэ түүх бүр хожим Иаков гэдэг овог аймгийн хүнтэй холбогдсон гэдэг.

Мэдээж хэрэг хэв маягийн шүүмж нь Библийн текстийн бүтэц ба хэв маягийн онцлогийн ач холбогдлын талаар зөв зүйтэй асуудлуудыг дэвшүүлсэн байдаг. Гэхдээ эх сурвалжийн шүүмжийн л нэгэн энэ нь адил олон янзын саад бэрхшээлтэй тулгарч байсан. Хэв маягийн шүүмжид тулгардаг бэрхшээл нь ялангуяа аман хэв маяг болон Библийн текстийн цаад нөхцөл байдлын тухай таамаг тайлбаруудад төвлөрдөг. Гэхдээ хэв маягийн шүүмж нь өнөөдөр ч гэсэн олон олон шүүмжлэлт эрдэмтдийг Бичвэрийн салшгүй хэсэг болсон Пентатухаас илүү эргэлзээтэй тайлбарууд руу хөтөлсөөр байна.

Уламжлалын шүүмж

Шүүмжлэлт эрдэмтэд Пентатухыг тайлбарлаж байсан гурав дахь гол арга замыг ихэнхдээ уламжлалын шүүмж эсвэл уламжлал - түүхийн шүүмж гэж нэрлэдэг.

Эх сурвалжийн болон хэв маягийн шүүмж дээр суурилан хөгжсөн уламжлалын шүүмжлэгчид нь эртний аман уламжлалууд болон бичгийн эх сурвалжууд хэрхэн теологийн болон улс төрийн бүрэн цогц үзэл суртал хараа болж хөгжсөнийг анхааран судалдаг. Тэргүүлэх эрдэмтэд болох Мартин Нот 1948 онд хэвлэгдсэн “Пентатухын Уламжлалын Түүх” номдоо, Герхард Вон Рад 1957 онд хэвлэгдсэн “Хуучин Гэрээний Теологи” хэмээх номдоо Пентатух нь янз бүрийн уламжлалын нөлөөг хэрхэн тусгасныг асуусан байдаг.

Мөн үүнээс гадна уламжлалын шүүмжлэгчид нь Пентатух дахь хоорондоо зөрчилддөг теологийн итгэл үнэмшлийн талаарх байр сууриа тодорхойлсон байдаг. Тэд Пентатухт бүтээл, өвөг дээдэс, Египетээс чөлөөлөгдсөн болон Амлагдсан газрыг эзэлсэн зэрэг сэдвүүдийн талаарх олон янзын уламжлалын нэгдлийг хэрхэн тусгасныг тэмдэглэсэн байдаг. Мөн тэдний судалдаг асуудлуудаас цөөн хэдийг дурдахад л Израилын овгууд, Давидын хаан ширээ, Йерусалимын сүм гэх мэт байна. Мөн тэд теологийн эдгээр цогц уялдаа холбоо нь Пентатух дахь ихэнх гол сэдвүүдэд гүнзгий нөлөө үзүүлсэн гэдэгт итгэдэг.

Дахин хэлэхэд уламжлалын шүүмжийн тодорхой дүгнэлтүүдийн ихэнх нь өдийг хүртэл эргэлзээтэй байсаар ирсэн. Гэсэн хэдий ч Хуучин Гэрээний тайлбарлагчдын Израилын уламжлалуудын өөр хоорондоо зөрчилддөг эсвэл бүр сөргөлддөг олон янзын урсгалыг тусган харуулсан хэсгүүдийн талаарх ярианаас нь бид энэхүү хандлагын ул мөрийг олж харж болно.

Найруулгын шүүмж

Шүүмжлэлт тайлбарлагчид Пентатухын хөгжлийн талаарх дүгнэлт хийж ирсэн дөрөв дэх гол арга замыг найруулгын шүүмж гэдэг. Шүүмжийн энэ арга барил нь таамаг баримт бичгүүдийг хэрхэн найруулан засаж, өнөөгийн бидний мэдэх Пентатух болсонд голлон анхаардаг.

Найруулгын шүүмж нь анх Шинэ Гэрээ судлалд Сайнмэдээний номуудын ялгааг тайлбарлах арга зам хэлбэрээр хорьдугаар зууны үеэс үүсэн бий болсон.

Найруулгын шүүмжлэгчид эдгээр ялгаанууд нь өмнө бичигдсэн байсан зүйлсийг дахин найруулан засах үед бий болсон гэж үздэг.

Пентатухт адил төстэй арга техникүүдийг ашигласан байдаг. Өөр өөр хүмүүс хэрхэн эртний “Ж”, “Э”, “Д” зэрэг бичгийн эх сурвалжуудыг авч, Пентатухыг өнөөгийн эцсийн хэлбэрт оруулж найруулсныг тайлбарлах оролдлогууд хийгдсээр байжээ. Энэ шүүмж нь “П” суралжийн сүүлийн найруулгад гол анхаарлаа хандуулсан.

Найруулгын шүүмжийг өнөөдөр ч Библид буй Эхлэлээс Дэд хууль хүртэлх номуудад анхаарал хандуулдагараа давуу байв. Гэхдээ найруулгын шүүмж нь эх сурвалжийн, хэв маягийн болон уламжлалын шүүмжийн дүгнэлтүүдтэй хэзээ ч зөрчилдөж байгаагүй.

Орчин цагийн шүүмж

Одоо харин бид Пентатухын өнөө цагийн хамгийн нөлөө бүхий буюу орчин цагийн шүүмжлэлт хандлагыг тодорхойлдог зарим чиг хандлагуудыг энд дурдах болно.

Ойрын хэдэн арван жилийн дотор цөөнгүй шүүмжлэлт тайлбарлагчид эртний түүхэн онол тайлбаруудаас илүү зүйлсийг эрж хайсаар байна. Эдгээрийн оронд тэд Пентатухын уламжлалт Еврей эх сурвалжийн гүн гүнзгий утга болон теологийн нэгдэлд илүү их анхаарах болсон байна. Эдгээр чиг хандлагууд нь олон янзын хэлбэртэй болсон. Тэдгээрээс цөөн хэдийг дурдвал яруу илэрхийллийн шүүмж, каноны шүүмж, шинэ утга зохиолын шүүмж гэх мэт байна. Гэхдээ тэд бүгд л Пентатух нь синагогууд болон чуулганаар дамжин бидэнд ирсэн гэж үзэж үүнийг тайлбарладаг. Пентатухыг авч үздэг сүүлийн хэв маяг нь өмнөх шүүмжлэлт хандлагуудаасаа илүү найдлага төрүүлдэг. Гэхдээ орчин цагийн эдгээр чиг хандлагууд нь эцэстээ ямар үр жимс гаргахыг гагцхүү цаг хугацаа л бидэнд харуулах биз ээ.

Ингээд бид “Пентатухын танилцуулга” хичээлээрээ бид Библийн энэ хэсгийн талаарх орчин цагийн шүүмжлэлт хандлагуудын талаар авч үзлээ. Харин одоо энэ хичээлийн хоёр дахь гол сэдэв болох Пентатухын талаарх орчин цагийн эвангелийн үзэл санааны тухай үзье. Эвангелийн үзэл санааг баримтлагчид өнөө цагт Библийн эхний таван номын талаар ямар чиг хандлагатай байдаг вэ?

ОРЧИН ЦАГИЙН ЭВАНГЕЛИЙН ЧИГ ХАНДЛАГУУД

Хичээлийнхээ зорилгын дагуу өмнө нь бид эвангелийн итгэгчид гэдэг нь Бичвэрийн бүрэн эрх мэдлийг баримталдаг хүмүүс хэмээн тодорхойлсныг та бүхэн санаж байгаа байх. Эвангелийн итгэгчид энэхүү итгэл үнэмшлээ үргэлж нэгэн адил арга замаар хэрэгжүүлж байгаагүй гэдгийг энд дурдах нь илүүц байх. Гэвч Бичвэрийн эрх мэдлийг тууштай баримталдаг тул тэд орчин цагийн шүүмжлэлт судлаачдаас их өөрөөр Пентатухд ханддаг юм.

Пентатухын талаарх орчин цагийн эвангелийн үзэл санааг бид өмнөх хичээлүүдтэйгээ адил дарааллаар хураангуйлан үзэх болно. Нэгдүгээрт, биднийг хөтлөн чиглүүлэх учиртай зарим чухал евангелист таамгуудыг авч үзнэ. Хоёрдугаарт, Пентатухын бичээчийн эрх мэдлийн талаарх эвангелийн үзэл санааны тухай үзнэ. Харин гуравдугаарт, бид үүнийг тайлбарладаг эвангелийн зарим гол стратегийн тухай ярилцана. Ингээд эхлээд эвангелийн зарим чухал таамгуудын талаар ярилцацгаая.

ЕВАНГЕЛИСТ ТААМГУУД

Бид шүүмжлэлт болон эвангелийн үзэл санааг харьцуулан харах хоёр л таамгаар өнөөдрийн хичээлээ хязгаарлах болно. Эхлээд бид сүпернатурализмд буюу ер бусын зүйлст итгэх итгэлээ шалгах болно. Хоёрдугаарт, Израилын итгэлийн түүхэн хөгжлийн талаарх таамгуудыг авч үзнэ. Тэгэхээр эхлээд сүпернатурализмд итгэх итгэлийн тухай харцгаая.

Сүпернатурализм

“Сүпернатурал” гэдэг үг бол орчин цагт “натурал” гэдэг үгнээс ялгаж салгахын тулд гаргаж ирсэн үг л дээ. Мэдээж бид Бурханд итгэдэг бол Бурхан бүх зүйлээр дамжуулан ажилладаг гэдэгт ч итгэдэг. Шотландын скептик философич Давид Хюме иймэрхүү ялгааг анх гаргахдаа “Бид сүпернатурал үйл явдлуудад итгэх шалтгаан байхгүй” гэж хэлсэнээс хойш энэ харин асуудал болсон. Библийн үнэн зөв байдлын тухай олон хүн маргах болсны нэг шалтгаан энэ байсан. Яагаад гэвэл тэд Библи чинь ер бусын гайхамшгаар дүүрэн. Гэтэл бид гайхамшиг байдаггүй гэдгийг мэднэ гэж тэд хэлдэг. Үгүй ээ, тэгвэл гайхамшиг болдоггүй гэдгийг яаж мэдсэн юм бэ гэхээр Давид Хюме тэгж “баталсан” гэдэг. Тэгвэл түүний баталсан онолыг эргээд сайн харах юм бол үнэндээ тийм ч сайн баталгаа биш байдаг. Түүний баталгааны гол санаануудын нэг нь бидэнд тухайн гайхамшгуудыг яг болсон гэдгийг нүдээр харж гэрчилсэн хэн ч байхгүй учраас тэдгээр гайхамшгуудыг өнөөдөр шалгаж баталгаажуулах боломжгүй гэдэг. Энэ үнэндээ тийм сайн баталгаа болж чадаагүй юм. Гэтэл Хюмегийн амьдарч байсан цаг үед ч бас Бурхан гайхамшгаа үйлдсээр байсныг нүдээрээ харсан хүмүүс байж л байсан. Өнөөдөр

ч бидэнд нүдээр харсан гэрчүүд бүр олон бий... Хэрэв эдгээр нь одоо ч бий болдог юм бол авралын түүхийн чухал мөчид Бурхан ажиллах үед эдгээр гайхамшгууд нь хэр их тохиолдож байсан бол оо?

— Др. Крэйг С. Кийнэр

Бурхан түүхийг энгийн тодорхой загвараар удирддаг гэж Бичвэрт заадаг. Тэдгээр загварыг ялгаж таних хэрэгсэл болгон Бурхан бидэнд учир шалтгааныг тооцох ухаан болон шинжлэх ухааныг бэлэг болгон өгсөн. Энэ бол эвангелийн итгэгчид Пентатухыг судлахдаа оновчтой шинжлэх ухааны судалгааг зүй ёсоор хүлээн зөвшөөрдөг шалтгаан юм. Мөн үүний нэгэн адил Есүсийн дагалдагчид бид Бурхан энэ дэлхийн бүхий л зүйлд сүпернатурал буюу ер бусын байдлаар оролцож байсан, оролцсоор байгаа гэдэгт ч итгэдэг. Бурхан энгийн үйл явц болон байгалийн жам ёсны ердийн үзэгдлээс үл хамааран, тэдгээрт захирагдахгүйгээр эсвэл бүр эсрэг ч ажилладаг. Яг энэ итгэл бидний Пентатухын судлалд олон талаар нөлөөлдөг. Нэн ялангуяа Бурхан бичвэрийн тэдгээр хэсгүүдийг зориудаар, онгодоор хөтлөн Бичвэрт оруулсан гэдэг нь баталгаатай. Тиймээс бичвэрийн тэдгээр хэсгүүд нь бүрэн дүүрэн эрх мэдэлтэй, итгэмжит Үгс мөн. Мэдээж бид Пентатухын жинхэнэ утга санааг өөрсдийнхөөрөө буруу тайлбарлахгүй байхад анхаарах хэрэгтэй. Бид тайлбараа үргэлж нягтлан сайжруулах шаардлагатай. Харин эвангелийн үзэл санаа бол Пентатухт үнэн гэж тунхагласан бүхэн нь Бурханы онгодоор бичигдсэн тул үнэн гэж үздэг.

Тэгэхээр сүпернатурализмын талаарх таамгууд биднийг Израилын итгэлийн түүхэн хөгжлийн талаарх таамгууд руу хөтлөн чиглүүлж байна.

Түүхэн хөгжил

Орчин цагийн шүүмжлэлт судлаачид Израилын итгэл эртний ойрх дорнодын бусад шашнуудын адил аяндаа хөгжиж ирсэн гэж маргадаг тухай бид өмнө үзсэн. Харин эвангелийн итгэгчид Израилын итгэлийг онцгой тэнгэрлэг илчлэлээр дамжин хөгжсөн гэж итгэдэг. Бурхан Өөрийгөө Адамаас эхлэн Ноа гэх мэт эрчүүд ба эмэгтэйчүүдэд шууд илчилж байсан. Мөн Тэрээр Израилын өвөг дээдэс болсон Абрахам, Исаак, Иаковт үгээ хэлдэг байсан. Тэрээр Мосетой шатаж буй бутан дотроос ярьсан. Синай уулан дээр Израилд Хуулиа өгсөн гэх мэт эдгээр илчлэлүүд нь Израилын итгэлийг эртний Ойрх дорнод дахь бусад шашнаас өөрөөр хөгжихөд хүргэсэн юм. Мэдээж Бурханы нийтлэг нигүүлсэл болон Сатаны нөлөө нь бусад шашнууд болон Израилын итгэл үнэмшлийн хооронд ижил төстэй зүйлсийг бий болгосон нь лавтай. Гэсэн ч Израилын итгэл байгалийн жамаар өөрөө аяндаа бий болоогүй. Харин Пентатухт өгүүлсэнчлэн Бурхан ер бусын гайхамшгаараа Израилын эхэн үеийн итгэлийг бий болгон хөгжүүлсээр ирсэн.

Ингээд бүгдээрээ Пентатухын талаарх орчин цагийн эвангелийн үзэл болон энэ үзэл шүүмжлэлт чиг хандлагаас юугаараа ялгардаг тухай авч үзлээ. Эдгээр үзлүүд нь Пентатухын эрх бичээсийн талаар тун ялгаатай итгэл үнэмшлийг бий

болгож болгосон байдаг. Шүүмжлэлт судлаачид Пентатух нь Мосегийн цаг үеэс гаралтай гэдгийг үгүйсгэдэг бол эвангелийн итгэгчид нь Пентатух нь Мосегийн цаг үеэс гаралтай гэдэг Иудейн болон Христитгэлийн урт удаан түүхтэй итгэл үнэмшлийг баримталдаг.

Бичээч

Пентатухыг хэн бичсэн бэ? гэдэг талаарх эвангелийн үзэл санааг судлахын тулд бид үүнийг хоёр чиглэлд авч үзэх болно. Эхлээд бид энэ үзлийг батлах Библийн зарим нотолгоог дурдах болно. Харин дараа нь орчин цагийн эвангелийн итгэгчид “Мосег бичээч гэх үндэс” гэж нэрлэдэг итгэл үнэмшлийг хэрхэн дагах болсныг тайлбарлана. Тэгэхээр эхлээд Мосе үүнийг бичсэн гэдгийг батлах Библийн нотолгоог үзэцгээе.

Библийн нотолгоо

Мосе бол Пентатухыг бичсэн хүн мөн гэдэг уламжлалт үзлийг батлах Библийн нотолгоо нь Бичвэр хангалттай их бий. Гэхдээ бидэнд тийм хангалттай их цаг байхгүй тул Библийн гурван өөр хэсгээс цөөн хэдэн нотолгоог авч үзэцгээе. Шинэ Гэрээний нотолгоог эхлээд үзье. Лук 24:44-р эшлэлд Есүсийн хэлсэн үгийг сонсоно уу. Тэрээр энд:

“Та нартай хамт байхдаа Миний ярьж байсан ёсоор Мосегийн хууль, Эш үзүүлэгчид болоод Дуулал дахь Миний тухай бичигдсэн бүхэн биелэгдэх ёстой” гэжээ (Лук 24:44).

Энэ эшлэлд Есүс тухайн цаг үеийн Иудей хүн бүрийн л адил Хуучин Гэрээг бүхэлд нь гурван хэсэгт хуваасан байна. Эдгээр нь Мосе, Эш үзүүлэгчид болон Дуулал юм. Лук энэ загвартай уялдуулан Есүс Пентатух буюу Тораг Мосетай хамааруулсан гэжээ.

Мөн Иохан 5:46 дээр Есүс Мосег Пентатухыг бичсэн гэдгийг тодорхой хэлсэн байдаг. Тэрээр энд:

“Хэрэв та нар Мосед итгэсэн юм бол Надад итгэх байсан. Учир нь тэр Миний тухай бичсэн юм” гэжээ (Иохан 5:46).

Есүсийн эдгээр гэрчлэлээс гадна Шинэ Гэрээний өөр хэсгүүдэд ч бас Пентатухын тодорхой хэсгүүдийг Мосе бичсэн хэмээн хэлсэн байдгийг бид Марк 7:10, Иохан 7:19, Ром 10:5, болон 1 Коринт 9:9 зэрэг эшлэлүүдээс харж болно.

Гэхдээ үнэн хэрэгтээ Шинэ Гэрээ Мосег бичээч нь гэдгийг батлахдаа Хуучин Гэрээний гэрчлэл дээр л тулгуурласан байдаг юм шүү дээ. Хуучин Гэрээний номуудад Пентатухыг Мосетай холбосон олон тохиолдол байдаг. Жишээ нь 2 Шастир 25:4 -р эшлэлд хэлэхдээ:

“[Амазиах] Мосегийн хуулийн номд бичигдсэний дагуу” гэсэн байдаг... (2 Шастир 25:4).

Мосег Пентатухтай холбосон үүнтэй төстэй Хуучин Гэрээний эшлэлүүд олон байдаг нь 2 Шастир 35:12, Езра 3:2 болон 6:18 мөн Нехемиа 8:1 болон 13:1 зэрэг юм.

Шинэ Гэрээ болон Хуучин Гэрээний эдгээр нотолгоонууд нь ихэнхдээ бичээчийнхээ тухай Пентатух өөрөө юу гэж хэлсэн гэдэгт тулгуурласан байгааг онцлох хэрэгтэй. Шулуухан хэлэхэд Пентатухын ихэнх хэсгийг хэн бичсэн нь тодорхойгүй байдаг. Дэд Хууль номын эхний эшлэлийг эс тооцвол эдгээр номуудын эхлэл төгсгөлийн алинд ч Мосег бичээч нь гэж дурдаагүй байдаг. Гэхдээ энэ бол эртний Ойрхи дорнодод тийм ч ховор үзэгдэл байсангүй. Үнэндээ Мосе Бурханаас илчлэлүүдийг хүлээн авсан бөгөөд Пентатухыг бичих үүрэгтэй байсан гэдгийг Пентатух өөрөө тов тодорхой хэлдэг. Тухайлбал, Гэтлэл 24:4 дээр Мосег Гэтлэл 20:18–23:33 дээрх Гэрээг бичсэн нэгэн гэдгийг хэлж өгдөг. Леви 1:1-2-р эшлэлээс бид Левичүүдийн хууль дүрмийг Мосегоор дамжуулан Израилд өгсөн гэдгийг мэддэг. Дэд Хууль 31:1 болон 32:44 дээрээс бид Дэд хууль ном дахь үгсийг Мосе хэлсэн гэдгийг олж мэддэг. Товчхондоо Пентатухын ихэнх хэсгийг хүлээн авч, дамжуулахад Мосе идэвхтэй оролцсон болохыг Пентатух өөрөө ил тодорхой хэлж өгсөн байна.

Эдгээр болон бусад Библийн нотолгоонууд нь эвангелийн итгэгчид яагаад Пентатухын бичээчийн талаарх шүүмжлэлт таамгуудыг хүчтэй эсэргүүцэж байсан шалтгаан юм. Мөн Пентатухыг Мосегоос хамаагүй хойно бичсэн гэдэг шүүмжлэлт таамгийг Бичвэр дэмждэггүй нь ч тодорхой байна. Хэрэв бид Хуучин ба Шинэ Гэрээний гэрчлэлүүдийг дагавал Пентатухыг Мосетэй холбох нь зөв гэдэгт итгэлтэй байж болно.

Пентатух Мосетэй холбоотой гэдгээ өөрөө бидэнд хэлж өгдөг нь хамгийн чухал юм. Гэтлэлээс Дэд Хууль хүртэл Мосе бол яахын аргагүй гол дүрүүдийн нэг мөн. Бичээс өөрөө Мосегийн үеийнх гэдгийг илтгэдэг. Жишээ нь, Гэтлэл номд... Яавэ Бурхан Мосед Гэрээний ном буюу Гэтлэл 21-23-р бүлгийг бич гэж хэлсэн байдаг. Левит номоос бид Мосегийн дараалсан үгс болон заасан хуулиудыг харж болно. Тооллого номын гол дүр бол Мосе гэдэг нь ойлгомжтой. Дэд хууль номд Мосе олон удаа үгээ хэлсэн байдаг. Мөн энэ хэсгийг Мосе бичиж тахилчдад өгсөн тухай ч энд хэд хэдэн удаа дурдсан байдаг. Мэдээж Мосе бүхлээр нь бичсэн гэж яг хэлээгүй боловч нэлээн их хэсгийг бичиж тахилчдад өгсөн гэдгийг Дэд хууль ном өөрөө бидэнд тодорхой хэлж өгдөг. Тэгэхээр жишээ нь Дэд хууль номоос харвал Мосе бол эцсийн бичээч нь мөн эсэхээс үл хамааран дор хаяж 90 хувь орчмыг нь тэрээр өөрөө бичсэн гэдэг нь тодорхой байна.

— Др. Гордон. Х. Жонстон

Ингээд Мосе Пентатухыг бичсэн гэдэг үндсэн ойлголтыг баталгаажуулах Библийн нотолгоог авч үзлээ. Одоо харин бүгдээрээ хоёр дахь сэдэв руугаа орцгооё. Мосег бичээч гэх үндэс гэснээрээ орчин цагийн эвангелийн итгэгчид чухам ямар утга санааг илэрхийлдэг вэ?

Мосег бичээч гэх үндэс

Эвангелистууд Пентатухын талаарх шүүмжлэлт үзэл баримтлалуудад олон янзаар хариулсан байдаг. Харин хорь дугаар зууны дунд үеэс эхлэн Пентатухийн талаар “Мосег бичээч гэх үндэс”-ийн тухай ярих нь тун түгээмэл болсон байна.

Эдвард Ж. Яанг 1949 онд хэвлэгдсэн *Хуучин Гэрээний Танилцуулга* хэмээх номдоо энэ үзлийг хураангуйлан дүгнэсэн байдаг. Энд:

Бид Пентатухыг... Мосе бичсэн гэж батлахдаа түүний үг бүрийг нь бичсэн гэж хэлж байгаа хэрэг биш юм... [Тэрээр] өмнө нь байсан бичгийн эх сурвалжуудын зарим хэсгийг ашигласан байж болох талтай. Түүнчлэн Ариун Сүнсний онгодоор хөтлөгдөн хожим нь бага зэрэг нэмэлт, өөрчлөлт хийсэн байж ч магадгүй юм. Гэхдээ л үндсэндээ хамгийн гол нь энэ нь Мосегийн бичсэн бүтээл мөн.

Гэхдээ эвангелийн итгэгчид Мосег бичээч нь мөн гэдэг үзлийн нарийн ширийн зүйлсийг олон янзаар ойлгодог. Гэхдээ аль ч нөхцөлд “Мосег бичээч гэх үндэс” гэдэг үгийг хараад бид гурван хүчин зүйлийг санаж байх учиртай. Эдгээр нь Мосегийн ашигласан эх сурвалжууд, Пентатухыг бичсэн үйл явц, Мосегийн дараа Пентатухыг дахин хянан засварласан зэрэг нь юм. Тэгэхээр эдгээрээс эхлээд Мосегийн ашигласан эх сурвалжийн тухай авч үзье.

Эх сурвалжууд. Бурхан Өөрийгөө Мосед өөр өөр арга замуудаар илчилж байсан гэдгийг Бичвэрээс бид хардаг. Тухайлбал, Бурхан анхны арван хуулийг Өөрийн мутраар бичсэн. Тэгээд Синай уулан дээр Бурханы Мосед өгсөн хуулийг Гэрээний номд оруулсан байдаг. Гэхдээ Бичвэрийн олон хэсгийн нэгэн адил Мосе Пентатухыг бичихдээ нэмэлт өөр эх сурвалжийг ашигласан гэдэг нь тодорхой байна.

Нэг талаас тэр олон янзын аман уламжлалуудаас ашигласан байж болно. Жишээ нь, Мосе өөрийн төрсөн эх болон өсгөсөн гэр бүлийнхнээсээ бага балчир байхдаа сурсан зүйлсээ ашигласан байж болно. Мөн үүнээс гадна Гэтлэл 18:17-24-р эшлэлд Мосе Мидиан хүн Иетро хэмээх хадам аавынхаа зааврыг хурдан хүлээж авдаг байсан тухай гардаг.

Пентатухын аль нэг хэсэгт, тэр дундаа эртний түүх эсвэл үүнтэй холбоотой аман уламжлалуудын тухай ярих бүрд энэ нь жаахан бүрхэг санагддаг. Учир нь баттай нотолгоо байхгүй шүү дээ. “Аман” гэж хэлж байгаагийн учир нь энэ юм. Энэ нь бичигдэж үлдсэн зүйл байхгүй гэсэн үг. Гэхдээ үүнийг дахиад сайн бодоод үзвэл Мосе нэг өдөр л гэнэт нэг түүх зохиочхоогүй юм. Эсвэл Бурхан хүмүүсийн огт мэдэхгүй түүхийг түүнд ярьж өгөөгүй юм.

Үүнийг ойлгоход бидэнд туслах хэд хэдэн зүйлийг бид мэднэ. Үүний нэг нотолгоо нь өнөөдөр ч эртний түүхийн олон зүйлс үлгэр домог, эртний хүмүүсээс үеэс үед дамжин ирсэн эртний түүхүүд дээр л тулгуурладаг шүү дээ. Тэгээд тийм түүх нь Библийн цаг үетэй зэрэгцэн очих нь түгээмэл. Мөн Пентатух дахь багтай нэг нотолгоо бол Гэтлэл, Тооллого номуудад гардаг түүхүүдийг Дэд Хууль номд ч бас давтагдсан байдаг явдал юм. Мөн Дэд Хууль номд Мосегийн хэлсэн үг болон заасан сургаал номлолууд нь Гэтлэл болон Тооллого номуудад ч бий. Хамгийн гол нь тэдгээр давтагдаж буй зүйлс нь ижил төстэй ч яг таг адилхан биш байдаг нь тун сонирхолтой. Израилд Мосегийн цаг үед өмнө нь болоод өнгөрсөн түүх домгийг болон эдгээр нь үеэс үед хэрхэн уламжлагдан ирсэн тухай ярилцаж, тэдгээрийг амьдралдаа хэрхэн ашиглах тухай бие биедээ ярьж өгдөг тийм нэг соёл уламжлал байсан. Мэдээж Мосе ч бас бага насандаа ээжтэйгээ хамт байхдаа өвөг дээдсийнхээ тухай түүхийг, өөрийн Еврей угсаа гарал буюу Абрахамын үр удам гэдэг тухай сонсож өссөн байж таарна. Иетрогоос холдон Израилын ахмадууд дээр эргэн ирсний дараа өөрийн өвөг дээдсийн түүхийг илүү их суралцсан байх. Тиймээс Мосе ч үеэс үед дамжин ирсэн аман уламжлал болон түүхүүд дээр тулгуурлан Пентатухын зарим хэсгүүдийг бичсэн гэж үзэх хангалттай үндэслэл бидэнд бий.

— Др. бага. Ричард Л. Пратт

Аман уламжлалын нөлөө нь Мосегийн шатаж буй бутан дотроос авсан дуудлагын гайхалтай онцлог талуудыг тайлбарладаг. Гэтлэл 3:13, 16-р эшлэлд юу гэж хэлснийг харцгаая. Энд:

“Тэгэхэд Мосе, Бурханд

—Хараач, би Израилын хөвгүүд дээр очиж, тэдэнд “Эцэг өвгөдийн чинь Бурхан намайг та нар луу илгээв” гэж хэлэхэд тэд надаас “Түүний нэр хэн бэ?” гэж асуувал би тэдэнд юу гэж хэлэх вэ? гэв.” ... “Эцэг өвгөдийн чинь Бурхан, Абрахам, Исаак, Иаковын Бурхан ЭЗЭН надад үзэгдэн ...гэж хэл” гэжээ (Гэтлэл 3:13, 16).

Бурхан Мосед Өөрийгөө шууд л “Эзэн” эсвэл Яавэ “Абрахам, Исаак, Иаковын Бурхан” гэж хэлснийг анзаараарай. Тэгэхээр Мосед өмнө нь хэн нэгэн нь Яавэгийн болон эцэг өвгөдийн уламжлалын тухай хэлж өгсөн байх учиртай. Үгүй бол Бурханы энэ үгийг сонсоод Мосе юу ч ойлгохгүй байх байсан. Харин энэ эшлэлээс бид Мосе ямар ч гайхсан асуулт асуухгүйгээр Бурханы зааврыг хүлээн авахад бэлэн байгааг харж байна.

Пентатухыг бичихдээ Мосе бие даасан эх сурвалжуудыг ч бас ашигласан гэдэгт бид илүү итгэлтэй байж болно. Бид энэ талаар Гэтлэл 24:7 зэрэг эшлэлүүдээс харж болно. Энэ эшлэлээс бид Мосе эхлээд “Гэрээний ном”-ыг тусад нь бичсэн

боловч хожим нь Гэтлэл номд багтаан оруулсныг мэдэх боломжтой. Мөн Тооллого 21:14-15-р эшлэлд Мосе тухайн үеийн “Эзэний тулаануудын ном” -ноос газарзүйн нэршлийг эш татан оруулсан байдаг.

Үүнээс гадна Эхлэл 5:1 дээр мөн “Адамын удмын ном” гэсэн гадаад эх сурвалжаас эш татсан нь тодорхой байдаг. Энэ эшлэл дэх үг хэллэгийн орчуулгаас харахад Мосе Адамын удмын талаарх Еврей хэлээр *רִפְּו* (*sēpher*) буюу - “ном”, “хуйлмал бичээс” -ээс мэдээллийг оруулсан байх боломжтой харагддаг.

Мөн үүн дээр нэмж хэлэхэд Гэтлэл 17:14-р эшлэлд тулааны тухай дурдсан байдаг. Бурхан Мосед хандан хэлэхдээ:

“Үүнийг дурсгал болгон номд бичиж, Иошуагийн чихэнд хоногшуул” гэжээ (Гэтлэл 17:14).

Бурханы Мосед өгсөн тушаалаас тэрээр Пентатухыг бүхэлд нь бичихээс нэлээн өмнө тухайн зүйлийг дангаар нь бичиж байсан нь тодорхой байна.

Пентатухыг харахад, нэн ялангуяа Эхлэл номын хувьд Мосе эртний баримт бичгүүдийг боловсруулан бичсэн нь ойлгомжтой байдаг. Мосе дор хаяж дөрвөн хэлтэй байсныг бид мэднэ. Тэр Египет хэлтэй байсан. Мөн түүний Еврей ээж асрагч эх нь байсан учраас Еврей хэлтэй байсан нь гарцаагүй. Тухайн үеийн олон улсын худалдаа болон дипломат харилцааны албан ёсны хэл байсан Аккадиан хэлийг ч эзэмшсэн байсан. Арамей хэлээр Израилчууд эрт үеэс буюу Абрахам, Исаак, Иаковын үеэс л ярьдаг байсан шүү дээ. Мосе үнэхээр сайн бэлтгэгдсэн, сайн боловсролтой хүн байсан нь Эхлэл номыг хэрхэн зохион байгуулж бичсэнээс нь харагддаг. Тэрээр энд тодорхой баримт сурвалжуудыг ашигласан талаараа өгүүлдэг. Учир нь тэрээр хэлэхдээ “эдгээр нь олон үеийн турш...” эсвэл “эдгээр баримтыг үзвэл” гэх мэт үгсийг арвантаа ашигласан байдаг. Өөрөөр хэлбэл тэрээр тухайн олон баримтыг үзэж харж, Арамей болон эртний Канаан зэрэг эх хэлнүүдээс нь уншигчдадаа зориулан Еврей хэлнээ орчуулж байсан харагддаг. Гэхдээ энэ бол зөвхөн Эхлэл номын тухай биш. Левит, Тооллого, мөн мэдээж Гэтлэл, Дэд Хууль гээд Пентатухын сүүлийн дөрвөн номыг харвал Мосе тус бүрийг нь яг газар дээр нь, үйл явдал дээр нь бичсэн байдаг. Тэр яг тэнд өөрөө байж, үйл явдлыг өрнүүлж байсан. Хамгийн чухал нь энэ бүгд Бурханы хийж байсан зүйлс байсан юм. Өөрөөр хэлбэл, эдгээр номуудын ихэнх нь Бурхан эш үзүүлэгчээрээ дамжуулан хэлсэн үгс шүү дээ.

— Др. Дуглас Стюарт

Евангелийн итгэгчид Пентатухыг Мосе бичсэн гэсэн гол үзлийг баримтлахдаа аман болон бичгийн эх сурвалжуудыг хүлээн зөвшөөрөхөөс гадна үүнийг олон янзын үйл явцын туршид боловсруулан бичсэнийг нь хүлээн зөвшөөрдөг.

Үйл явц. Юуны өмнө Мосе Пентатухыг бичихээсээ өмнө ихэнх хэсгийг хүмүүст ярьж өгсөн байдаг. Энэ нь Гэтлэл болон Дэд Хууль номын үгсээс тодорхой харагддаг. Пентатухын бусад хэсэг нь ч мөн эхлээд аман хэлбэрээр тэгээд хожим нь бичгийн хэлбэрээр Израил түмэнд хүрсэн харагддаг.

Мөн Мосе Пентатухыг бичихийн тулд бичээч буюу туслахыг ажиллуулдаг байсан байх. Мосе Египетийн хааны ордонд боловсрол эзэмшсэн учраас албан ёсны бичиг баримтыг бичээчээр бичүүлэх тогтсон хэв маягийг андахгүй мэддэг байсан нь лавтай. Израилын удирдагч хүний хувьд тэрээр Пентатухыг бүхлээр нь биш гэхэд ихэнх хэсгийг нь өөрийн хяналт дор бичээчээр бичүүлсэн байх боломжтой.

Бурханы онгодоор хөтлөгдөн Бичвэрийг бичсэн бусад хүмүүс ч бичээч ажиллуулдаг байсан нь Библид тодорхой бий. Жишээ нь, Иеремиа 36:4-р эшлэлд эш үзүүлэгч Иеремиа дагалдагч Барухад үгсийг нь бичих заавар өгсөн байдаг.

Үүний бас нэгэн нотолгоо нь Пентатухыг уран зохиолын олон янзын хэв маягаар бичсэн явдал юм. Жишээ нь, Эхлэл номын олон хэсэгт ашигласан уран зохиолын хүүрнэлийн хэв маягууд нь бие биеэсээ тун өөр байдаг. Мөн Дэд Хууль ном болон Пентатухын бусад номуудын Еврей хэлний хэв загвар болон давталтуудын хооронд ч ихээхэн ялгаа бий. Үүнийг тайлбарлах хамгийн боломжтой хувилбар нь эдгээр нь өөр өөр бичээчдийн ажил гэхээс өөр аргагүй билээ.

Мосег бичээч гэх үндэс гэдэг ойлголт нь зөвхөн түүний ашиглаж байсан эх сурвалж болон Пентатухыг бичсэн үйл явцынх нь тухай авч үздэггүй. Харин Мосегаос хойших Пентатухын засварууд ч мөн ордог.

Сайжруулалт. Шүүмжлэлт тайлбарлагчид Пентатухыг Израилчууд цөллөгөөс эргэн ирсний дараа л боловсронгуй болж эцсийн хувилбар нь бий болсон гэж үздэг тухай бид ярьсан шүү дээ. Харин эвангелийн итгэгчид Пентатух нь Мосегийн өдрүүдэд бий болж бичигдсэн ч түүнээс хойш зарим хэсэгт нь бага зэргийн засвар, сайжруулалт хийгдсэн гэдгийг хүлээн зөвшөөрдөг юм.

Гэхдээ бид Пентатухын зарим нэг хэсгүүдийн цаг хугацааны тухай ярихдаа тун болгоомжтой хандах хэрэгтэй. Жишээ нь, зарим судлаачид “Филистчүүд” гэсэн нэр орсон хэсэг бүр Мосегийн үеэс хойш бичигдсэн гэж үздэг. Гэхдээ энэ үзэл нь дараах гурван шалтгааны улмаас итгэл үнэмшил багатай байдаг. Эхнийх нь, тухайн бүс нутагт Филистчүүдийн оршин байсныг батлах археологийн мэдээ нь маргаантай байдаг. Хоёрдугаарт, Мосе “Филист” (“аялагч” гэсэн утгатай) гэдэг үгээр нийгмийн бүлгийнх нь ангиллыг нь илэрхийлсэн байх боломжтой. Гуравдугаарт, “Филист” гэдэг үгийг Мосегийн үед ашигладаггүй байсан байж болох ч түүнээс хойших үеийн уншигчдад зориулан энэ үгийг нэмж оруулсан байж болно.

Мөн үүнтэй яг адилаар тайлбарлагчид Эхлэл 36:31-43-р эшлэлд гардаг Едомын захирагчдын жагсаалт нь Мосегийн амьдарч байсан цаг үеэс хамаагүй хожуу үед хамаатай гэж маргадаг. Гэхдээ л Эхлэл ном дахь Едомын захирагчдын жагсаалтыг бүрэн тодорхойлж чадаагүй л байгаа. Мөн л энэ багц эшлэлийг Мосегаос хойш нэмж оруулсан ч байх магадлалтай.

Пентатухыг бага зэрэг засаж сайжруулсан бас нэг жишээ гэвэл Эхлэл 14:14-р эшлэлд бий. Энд:

“Тэгээд Абрам ач дүүгээ олзлогдсоныг сонсоод, гэрт нь төрж

бэлтгэгдсэн гурван зуун арван найман хүнийг удирдаж Дан хүртэл нэхэн хөөжээ” гэсэн байдаг (Эхлэл 14:14).

Энэ эшлэлд Абрахам дайснуудаа Дан хүртэл нэхэн хөөжээ гэжээ. Гэтэл Иошуа 19:47-р эшлэлээс бид Иошуагийн үе хүртэл тухайн нутгийг Дан гэж нэрлээгүй байсныг олж мэддэг. Тэгэхээр Эхлэл 14:14 дээрх газрын нэрийг шинэчилсэн нь тодорхой байна. Энэ төрлийн орчин цагтай уялдуулан засах нь хожмын уншигчдад Абрахамын түүхийн газар зүйн байршлыг ойлгоход тустай байсан нь лавтай. Энэ мэтчилэн Пентатухын цөөнгүй багц эшлэлүүдийг засаж сайжруулсан байдаг.

Пентатухын ийнхүү засварласан эшлэлүүдийн дотроос хамгийн их анхаарал татдаг нь Дэд Хууль 34-р бүлэг дэх Мосегийн нас барсан тухай тэмдэглэл байх. Гэхдээ энд ч гэсэн бидэнд Израилд хуулийг өгсөн нэгэнд юу тохиолдсон талаарх нэмэлт тайлбар бий.

Иймэрхүү жижиг сайжруулалтуудаас гадна Еврей хэл хөгжихийн хэрээр Пентатухын үг хэллэгүүд ч бас хөгжин өөрчлөгдсөөр ирсэн. Мосе судлаачдын нэрлэдэгээр “прото Еврей” гэдэг хэлээр бичсэнийг сүүлийн үеийн судалгаанууд баталсаар байна. Египетээс олдсон олдсон “Амарнагийн захидлууд” гэгддэг олон улсын баримт нь энэ төрлийн Еврей хэл нь Мосегийн цаг үеийн Канаан нутгийн хэл аялгатай холбоотой гэдгийг тодорхой харуулдаг. Гэхдээ үнэндээ энэ хэлийг Пентатухын уламжлалт Еврей хэлнээс ч өмнө хэрэглэж байсан юм.

Хуучин Гэрээний хэлний талаарх асуулт үнэндээ тун сонирхолтой. Энэ хэлийг хэзээ ашигласан... хаанаас гаралтай... хаана анх ашигласан гээд л. Археологийн олдворт үндэслэсэн нотолгооноос болоод энэ асуултууд хүмүүст их удаан эргэлзээтэй байсан. Эртний Еврей бичиг, Еврей хэл гэж байсан юм уу? Хорьдугаар зуунд олдсон бичгийн олдворууд бол бидэнд байгаа хамгийн сүүлийн үеийн олдворууд юм. Гэтэл тухайн одворуудаас харахад Мосегийн үеэс бүр хойшхи үед хамаардаг... Тэгэхээр одоо бид яах ёстой вэ? Бас бидэнд Христээс өмнөх арван гурав, дөрөвдүгээр зуунд хамаарах дипломат харилцааны бүр архивын олдвор бий. Гэхдээ тэдгээр нь Израилын газар нутаг болох Канаан нутгаас биш Египетээс олдсон... Тэдгээр олдворууд Месопотамиас гаралтай Аккадиан хэл дээр байдаг. Энэ бол тухайн үеийнхээ олон улсын дипломат харилцааны хэл байсан лингуа франка хэл юм. Гэхдээ Канаанчууд Египетийн захирагч нарт хандан бичсэн байдаг. Канаан хэл дээр багахан тэмдэглэлийг ч бичиж үлдээсэн байдаг. Чухам энд л гол учиг нь оршиж байна. Канаан хэл бол биднийг Мосегийн үеийн Еврей хэлтэй холбох гүүр. Мосегийн үеийн ямар ч олдвор үлдээгүй ч эндээс бид ямар холбоотойг харна. Энэ л бидний гүүр. Тэгэхээр Канаан хэл дээрх бичгүүдээс эхлэн цөллөгөөс өмнөх ихэнх үйл явдлыг бичсэн Мосегийн үеийн Библийн Еврей хэл хүртэл хөөгөөд үзвэл дээрх асуултуудыг ойлгож болно. Хэдий их тойруугаар холбогдож байгаа ч бидэнд жинхэнэ нотолгоо болж чадна.

— Др. Том Петтер

Христээс өмнөх 1000-600 оны үед буюу Израилын хаадын үед Еврей хэл нь одоогийн бидний “хуучин” буюу “палео- Еврей хэл” хэл болон хөгжсөн юм. Гэтлэл 15, Дэд хууль 32 гэх мэт Пентатухын зарим хэсгүүд Еврей хэлний энэ үеийн хэлтэй тун төстэй байдаг гэдэгтэй олон судлаачид санал нийлдэг.

Гэхдээ Пентатухын ихэнх хэсэг нь Христээс өмнөх 6-8-р зууны хооронд хөгжсөн “сонгодог Еврей” хэлтэй үгсийн сан, үгийн бүтэц, дүрмээрээ тун төстэй байдаг.

Энэ нотолгооноос Мосегийн ашигласан Прото- Еврей хэлийг Палео-Еврей хэл болгон сайжруулсан нь харагдаж байна. Тэгээд хожим нь сонгодог Еврей хэл болгон сайжруулж, одоогийн бидний ашигладаг Еврей хэл дээрх Библи болсон байна.

Есүс, Түүний дагалдагчид болон элч нарын үед Пентатухын Еврей хэл аль хэдийн эдгээр өөрчлөлт дундуур явсан байсан гэдгийг мартаж болохгүй. Гэсэн ч үүнээс болж Есүс болон Түүний дагалдагчид тэдний цаг үе дэх Пентатухыг Мосе өөрөө бичсэн гэдэгт огтхон ч эргэлзээгүй байна. Тиймээс Христийн дагалдагч болсон бидний хувьд одоогийн бидэнд байгаа Пентатух бол Мосегийн эх бичвэр мөн гэдэгт бас эргэлзэх хэрэггүй.

Тэгэхээр бид Пентатухын талаарх орчин цагийн евангелийн үзэл, таамгуудын тухай авч үзлээ. Мөн евангелийн итгэгчид Библийн энэ хэсгийг хэн бичсэн тухай юу гэж үздэг талаар ярилцлаа. Одоо харин тэдний эдгээр үзэл санаа нь тайлбарлах стратегид нь хэрхэн нөлөөлснийг зарим талаас нь авч үзье.

ЭВАНГЕЛИСТ ТАЙЛЛЫН СТРАТЕГИУД

Евангелийн итгэгчдийн тайлбарлах стратегийг тодорхойлох олон янзын арга зам бий боловч өнөөдөр бид тэдний баримталдаг гурван гол чиглэлийг авч үзэх болно. Эхлээд бид сэдэвчилсэн тайлбарын тухай үзнэ. Дараа нь түүхэн тайлбарын тухай үзнэ. Эцэст нь утга зохиолын тайлбарын тухай үзэх болно. Энэ гурван төрлийн тайлбар хоорондоо салшгүй холбоотой бөгөөд хэзээ ч тусад нь авч үзэж болохгүй. Гэсэн хэдий ч тус бүрдээ өөр өөр зүйлийг чухалчилдаг учраас тус бүрд нь авч үзэх нь зүйтэй. Эхлээд сэдэвчилсэн тайлбарын тухай үзэцгээе.

Сэдэвчилсэн тайлбар

Сэдэвчилсэн тайлбарт Пентатухыг бид өөрсдийн чухал гэж боддог асуудлын тусгал болгодог гэсэн үг. Евангелийн итгэгчид Библийн энэ хэсэг дэх тодорхой сэдэв болон асуудлыг чухалчлан үздэг нь зүй ёсны хэрэг мөн. Пентатухын ном бүр нь өөрөө ямарваа нэг сэдвийг угаас чухалчилсан байдаг. Тэгэхээр Мосе өөрөө тэдгээр сэдвүүдийг онцолсон эсвэл онцлоогүй ч байж болно. Энэ чиг хандлага нь

Христитгэлийн тайлбарын хэв маягийг мянган жилийн турш тодорхойлсоор ирсэн юм.

Христитгэгчдийн чухал гэж үздэг сэдвүүд маш урт жагсаалт болох нь мэдээж. Зарим нь хувь хүний асуултууд болон эргэлзээтэй асуудлуудыг хөнддөг. Зарим нь Пентатухыг системт теологийн уламжлалт үзэл баримтлалыг дэмжих зорилгоор ашигладаг. Жишээ нь, Пентатухт Бурханы тухай олон зүйлийг илчилсэн байдаг. Бас хүн төрөлхтний олон янзын асуудлуудын талаар хангалттай их зүйл бичсэн байдаг. Бүтээлийн тухай ерөнхийд нь их анхаарал хандуулсан байдаг.

Гэхдээ сэдэвчилсэн тайлбарын хамгийн дутагдалтай талуудын нэг бол яалт ч үгүй Мосегийн бичсэн анхны тэдгээр сэдвүүд нь чухамдаа Амлагдсан нутаг руу түүний дагуулан явсан Израилчуудад зориулагдсан гэдэг үнэнийг төдийлөн авч үздэггүй явдал юм. Анхны сэдэв агуулгад бараг анхаарал хандуулдаггүйгээс болж сэдэвчилсэн тайлбар нь жижиг сэдвүүд руу анхаарал татахаас өөр бараг ач тусгүй байх талтай.

Гэсэн хэдий ч бид Шинэ Гэрээн нь Пентатухын талаарх энэ чиг хандлагыг дэмжсэн байдгийг мартаж болохгүй. Есүс болон Шинэ Гэрээг бичсэн хүмүүс итгэлээр зөвтгөгдөх, салалт, итгэл ба үйлс гэх мэт Библийн харьцангуй жижиг сэдвүүдийн тухай ярихдаа Мосегийн номуудаас эш татдаг байсан. Тиймээс бид Бичвэрийг зөвхөн сэдвүүдийн талаас нь харахгүй байхад анхаарч, болгоомжтой байж чадвал сэдэвчилсэн теологи нь Пентатухыг судлахад үнэ цэнтэй арга зам байх боломжтой.

Сэдэвчилсэн тайлбарын тайлбарлах стратегиас гадна эвангелийн итгэгчид Пентатухыг судлахдаа ашигладаг бас нэгэн түгээмэл арга замыг бид түүхэн тайлбар гэж нэрлэдэг.

Түүхэн тайлбар

Эвангелийн итгэгчид зөвхөн Пентатухын теологийн сэдвүүдийг л үнэн гэж итгэдэггүй. Харин Есүс болон Мүүний элч, эш үзүүлэгчдийн жишээг дагаж, Пентатухт өгүүлсэн түүхийг ч мөн үнэн гэж үздэг. Тиймээс эвангелийн итгэгчид Пентатухыг өнгөрсөнд юу болсныг олж нээх арга болгон ашиглах талаас нь тайлбарладаг.

Сэдэвчилсэн тайлбарт бид Пентатухыг өөрсдийн чухал гэж үздэг асуудлуудыг харах толь болгон ашигладаг гэж түрүүхэн хэлсэн шүү дээ. Тэгвэл түүхэн шинжлэл нь Пентатухыг түүхийн цонх болгодог. Өөрөөр хэлбэл Мосегийн номуудыг уншихдаа тухайн үйл явдлуудын цаадах түүхийг судлахыг чухалчилдаг гэсэн үг.

Эхлэл номонд бүтээлийн өдрөөс эхлэн Иосефын үе хүртэл түүхийг өгүүлдэг. Гэтлэл номын түүх Иосефыг нас барснаас эхлэн Ирраичууд Мосетой хамт Синай уулын бэлд буудаллах хүртэлх түүхэн үйл явдлуудыг өгүүлсэн байдаг. Левит номд Мосе Синай ууланд байхдаа хүлээн авсан хууль, ёслолуудын тухай бичсэн байдаг. Тооллого номд Синай уулнаас Моабын тал нутаг руу нүүдэллэсэн анхны болон хоёр дахь үеийнхний тухай тэмдэглэсэн байдаг. Харин Дэд Хууль номд Канаан руу орохын өмнөхөн Моабын тал нутагт Мосегийн Израилчуудад сургасан, ярьсан

зүйлсийг өгүүлдэг. Түүхэн тайлбарт тэгэхээр эвангелийн итгэгчид ийм ил тод түүхэн үйл явдлуудыг илүү их тодотгон үздэг гэсэн үг.

Түүхэн тайлбар ач тустай хэдий ч Пентатухыг судлахад мөн л өөрийн гэсэн хязгаарлагдмал талуудтай. Сэдэвчилсэн тайлбарын нэгэн адил түүхэн тайлбар нь Мосе болон түүний анхны уншигчдад анхаарал хандуулах нь бага. Харин оронд нь Пентатухыг бичихээс ч өмнө өөр өөр цаг үед Бурхан юу хийсэн бэ гэдэг чиглэлийг голчлон баримталдаг. Бурхан Адам Ева хоёртой хамт юу хийсэн бэ? Ноагийн үер ямар ач холбогдолтой байсан бэ? Абрахам Бурхантай хэрхэн харилцдаг байсан бэ? Израил тэнгисийг гатлахад Бурхан ямар үүрэг гүйцэтгэсэн бэ? Эдгээрийн тухай олж мэдэх нь зүй ёсны хэрэг боловч эдгээр номуудыг бичсэн Мосе болон анхны уншигчдынх нь ач холбогдлыг ихээхэн орхигдуулдаг.

Гэхдээ л эвангелийн итгэгчид нь Пентатухын сэдэвчилсэн болон түүхэн тайлбараас олон талаараа ашиг тусыг хүртдэг нь мэдээж. Харин сүүлийн хэдэн арван жилд утга зохиолын тайлбар гэдэг гурав дахь чиг баримжааг бас түлхүү ашиглах болсон байна.

Утга зохиолын тайлбар

Сэдэвчилсэн дүн шинжилгээ нь Пентатухыг чухал гэж үзсэн сэдвүүдийн толь гэж үздэг. Харин түүхэн дүн шинжилгээ нь Пентатухыг бүр өмнө нь болсон түүхэн үйл явдлуудын харах цонх гэж үздэг гэж бид ярилцсан. Тэгвэл эсрэгээрээ утга зохиолын дүн шинжилгээ нь Пентатухыг анхны уншигчдадаа нөлөөлөхийн тулд зохион байгуулагдсан уран зохиолын бүтээл буюу хөрөг гэсэн талаас нь харж судалдаг байна. Мосе Пентатухыг бичиж байхдаа анхны уншигчдадаа ямар нөлөө үзүүлэхийг зорьсон бэ гэдэг асуулт бол утга зохиолын тайлбарын гол асуудаг зүйл юм.

Мосед олон зорилго байсан нь тодорхой. Гэхдээ тэдгээр зорилгуудыг ерөнхийд нь тайлбарлах нь бидэнд тустай. Тэгэхээр Мосегийн зорилгыг Бурханы томилсон удирдагч гэдэг үүднээс тайлбарлах болно,

Мосе Израилчуудыг Амлагдсан газрыг ялалт байгуулан авч, амьдран суурьшихдаа Бурханд итгэмжтэйгээр үйлчлэхэд бэлдэхийн тулд Пентатухыг бичсэн.

Өөрсдийн төсөөлөлдөө хөтлөгдөн сэдвүүдийн хойноос хөөцөлдөх, аль эсвэл түүхэн сонирхлын үүднээс үйл явдлуудыг л хөөн судлахаас илүүтэйгээр сэдэв бүр, түүхэн үйл явдал бүр энэ зорилгын төлөө бичигдсэн гэдгийг харж судлахыг зорьдог гэсэн үг.

Утга зохиолын тайлбар нь Мосе Пентатухыг бичиж байхдаа хоёр цаг үеийн хооронд зогсож бичсэн гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Нэг талаараа, Мосе бидний хэлдгээр “өмнөх ертөнц” буюу өнгөрсөн цаг хугацаанд болсон зүйлсийн тухай бичсэн. Эхлэл номд Мосегийн амьдарч байсан үеэс бүр эрт болж өнгөрсөн зүйлсийн тухай бичсэн байдаг. Гэтлэл болон Левит номд Египетээс гарсан анхны үеийнхний цаг үед болсон үйл явдлуудад голчлон төвлөрсөн байдаг. Тооллого болон Дэд Хууль номд харин анхны үеийнхээс дараа үед болсон зүйлсийн тухай бичсэн. Мосе

Пентатухын ном бүрийг бичихдээ өнгөрснөөс эхлээд эдгээр цаг үеүдийн тухай бодож байсан гэсэн үг.

Нөгөө талаасаа, Мосе “тэдний ертөнц” буюу анхны уншигчдынхаа цаг үед зориулан бичсэн. Тэрээр уншигчдадаа “тэдний ертөнц” Бурхандаа үйлчлэхийн тулд хэрхэн бодож, үйлдэж, мэдрэх ёстойг заахын тулд “өмнөх ертөнц” нь болж өнгөрсөн зүйлсийн тухай бичсэн юм. Энэ зорилгоо биелүүлэхийн тулд Мосе “өмнөх ертөнц” нь болсон зүйлсийг “тэдний ертөнц”-тэй нь холбон бичсэн.

Мосе өнгөрсөнд болсон зүйлсийг уншигчидтайгаа гурван арга замаар холбосон. Тэр тэдэнд одоогийн туулж буй бүхнийх нь уг үндэс суурь болсон өнгөрсөн зүйлсийг зааж өгсөн. Мөн юуг дуурайх болон юунаас сэргийлэхийг ч заасан. Тэрээр бүхнийг уншигчдынхаа амьдралд загвар эсвэл зөгнөл болгон боловсруулж бичсэн юм.

Яг иймэрхүү холбоог илүү тодорхой өгүүлсэн тохиолдлууд бий. Жишээ нь, Эхлэл 15:12-16-р эшлэлд Мосе уншигчдадаа хандан Бурхан тэднийг Египетээс чөлөөлнө гэсэн амлалтын талаар хэлсэн байдаг. Энэ амлалт нь тэдний цаг үед биеллээ олж байсан юм. Эхлэл 2:24-р эшлэлд, Мосе Адам Ева хоёрын гэрлэлтийг Бурханы итгэмжит хүмүүсийн үлгэр дуурайл болгон тайлбарласан. Харин Эхлэл 25:23-р эшлэлд Иаков, Есав хоёр эхийнхээ хэвлийд барилдсан нь тэдний цаг үед Израилчууд нь Едомчуудтай тэмцэлдэхийг зөгнөж байсан хэмээн мэдэгдсэн байдаг.

“Өмнөх ертөнц” болон “тэдний ертөнц” хоёрын хоорондох ийм тодорхой холбоо Пентатухын хаа сайгүй олон бий. Гэхдээ иймэрхүү ихэнх холбооснууд далд байдаг. Тиймээс утга зохиолын тайлбарын гол үүргүүдийн нэг бол Мосе “өмнөх ертөнц” болон “тэдний ертөнц” хоёрыг нь хэрхэн холбосныг ялгаж таних явдал юм.

Бүхэл мянганы туршид Пентатухыг тайлбарлахад сэдэвчилсэн болон түүхэн дүн шинжилгээг утгазохиолын дүн шинжилгээнээс илүү ашигласаар ирсэн. Тиймээс Мосегийн бичсэн номуудын тухай хичээлийнхээ ихэнх цагийг бид утга зохиолын тайлбарт зориулах болно. Мосе уншигчдынхаа туулж буй амьдралын уг түүхэн үндэс, үлгэр дуурайл, анхааруулга зөн болгохын тулд ном бүрийнхээ агуулгыг хэрхэн загварчлан боловсруулж байсныг бид нарийн задлан ярилцах болно. Мосе уншигчдадаа зориулан юуг илүү чухалчилж байсныг, номд бичиж байгаа зүйлсээ тэдний амьдралтай хэрхэн холбосныг, мөн Бурханд хэрхэн итгэмжтэй үйлчлэхийг ятган чиглүүлж байсныг бүгдээрээ үзнэ..

ДҮГНЭЛТ

Энэхүү Пентатухын танилцуулга хичээлээрээ бид Библийн энэ хэсгийн талаарх орчин цагийн зарим шүүмжлэлт чиг хандлагуудын тухай үзлээ. Шүүмжлэлт тайлбарлагчдын таамгуудаас Пентатухыг хэн бичсэн болон тайлбарын талаарх ямар ямар үзэл санаанууд урган гарч байсныг үзлээ. Мөн бид орчин цагийн эвангелийн үзлийн тухай үзсэн. Тэдний таамгууд нь Пентатухын бичээч болон тайлбарын талаарх өөр өөр үзэл санаанууд руу хэрхэн хөтлөн дагуулсныг судалж мэдлээ.

Пентатухын талаар цааш гүнзгийрүүлэн үзэхдээ бид эдгээр үндсэн ойлголтууддаа тулгуурлах болно. Ингэснээр бид Библийн энэ хэсгийг судлахад

бэлэн байх болно. Ингэхдээ бид Мосе яагаад Пентатухын тэдгээр номуудыг бичсэн бэ? Номуудын анхны зорилго нь юу байсан бэ? Пентатухын номууд анхны уншигчдадаа ямар нөлөө үзүүлсэн бэ? гэх мэт асуултуудын талаар судлах болно. Эдгээр асуултуудыг судалснаар бид Мосегийн анхны утга санаа болон зорилгын талаар тун чухал ойлголтыг олж авах болно. Мөн хамгийн гол нь Библийн эхний таван ном нь Мосегийн цаг үед Израилын итгэлийн жишиг шалгуур болж байсан төдийгүй өнөөдөр ч Христийг дагаж буй бидэнд хэрхэн жишиг шалгуур болох ёстой тухай бид олж мэдэх болно.

ХАМТРАГЧИД

Др. Скот Рэд (Хөтлөгч) бол Вашингтон Д.С дэх Шинэчлэлийн Теологийн Сургуулийн Ерөнхийлөгч, Хуучин Гэрээний Дэд Профессор. Др. Рэд нь M.Div. зэргээ Шинэчлэлийн Теологийн Сургуулиас авсан. М.А болон Ph.D зэргээ АНУ-ын Католик Их Сургуулиас авсан. Тэрээр мөн Малта дахь АНУ Католик Их Сургууль, Августин Теологийн Институти болон Газар дундын тэнгисийн Олон Улсын Сургалтын Хүрээлэнд багшилж байсан. Др. Рэд нь олон төрлийн ном зохиолыг хамтран бичсэн. Үүнд: *Tabletalk* (Ligonier Ministries), *The Washington Post* болон *First Things*. Түүнчлэн тэрээр *Constituent Postponement in Biblical Hebrew Verse* (Society of Biblical Literature, 2014) болон *Wholehearted: A Biblical Look at the Greatest Commandment and Personal Wealth* (Institute for Faith, Work & Economics, 2016) зэрэг номуудыг бичсэн.

Рев. Майкл Ж. Глодо бол Флоридагийн Орландо дахь Шинэчлэлийн Теологийн Сургуулийн Библи судлалын дэд профессор

Др. Гордон Х. Жонстон бол Даллас Теологийн Сургуулийн Хуучин Гэрээний профессор.

Др. Грейг С. Кийнэ бол Асбури Теологийн Сургуулийн Ф.М ба Ада Томпсоны Библи Судлалын Захирал.

Др. Жон Освалт бол Асбури Теологийн Сургуулийн Хуучин Гэрээний Хүндэт Зочин Профессор.

Др. Том Петтер Гордон-Конвэл Теологийн Сургуулийн Хуучин Гэрээний Профессор.

Др. бага. Ричард Л. Прагт бол Гурав дахь мянган үйлчлэлийн хамтран үүсгэн байгуулагч, ерөнхийлөгч. Тэрээр Шинэчлэлийн Теологийн Сургуульд Хуучин Гэрээний профессор.

Др. Брайн Д. Рассел бол Флоридагийн Орландо дахь Асбури Теологийн Сургуулийн Библи Судлалын Профессор, Урбан Үйлчлэлийн Сургуулийн Эрхлэгч.

Др. Дуглас Стюарт Гордон-Конвэл Теологийн Сургуулийн Хуучин Гэрээний Профессор.

Др. Давид Талли бол Байола Их Сургуулийн Теологийн Талбот сургуулийн профессор ба Библийн болон Теологи судлалын Хуучин Гэрээний тэнхимийн дарга.

ҮГСИЙН ТАЙЛБАР

амануенсис/amanuensis – Туслах бичээч эсвэл нарийн бичиг

Гэрээний Ном – Бурханы Синай ууланд Мосед өгсөн хуулийн цуглуулга. Энэ нь Гэтлэл 20:18–23:33 дээр гардаг.

Орчин цагийн шүүмжлэлт хандлага – Библийг эцсийн байдлаар тайлбарлахад голчлон анхаардаг сүүлийн үеийн нөлөө бүхий шүүмжлэлт хандлага

Дэд хуульч сурвалж ("Д")– Эх сурвалжийн шүүмжийн дагуу Пентатухт хамаатай утга зохиолын гурав дахь эх сурвалж. Энэ нь ихэвчлэн Дэд Хууль номд гардаг тул “Д” гэж нэрлэдэг.

Эл Элион – Библи дэх “Хамгийн Дээд Бурхан” гэсэн утгатай Бурханы нэр

Эл Шаддай – Библи дэх “Төгс хүчит Бурхан” гэсэн утгатай Бурханы нэр

Эл/Элохим – “Бурхан” гэсэн утгатай Еврей үг

Элохист сурвалж ("Э")– Эх сурвалжийн шүүмжийн дагуу Пентатухт хамаатай утга зохиолын хоёр дахь эх сурвалж. Эдгээр хэсгүүдэд Бурханыг ихэвчлэн “Элохим” гэж нэрлэсэн байдаг тул “Э” гэж нэрлэдэг.

эвангел/эвангелийн – Христитгэгчид болон олон янзын Христитгэлийн хөдөлгөөнийг илэрхийлдэг үг хэллэг. Шинэчлэгчид үүнийг ихэвчлэн Протестант урсгалыг Католикоос ялгахын тулд ашигладаг. Орчин цагт Бичвэрийн эрх мэдлийг хүлээн зөвшөөрдөг Христитгэгчдийг тодорхойлоход ашигладаг.

хэв маягийн шүүмж – аман уламжлалуудаас Пентатухын баримтат эх сурвалж бий болсон гэдэгт анхаардаг Хуучин Гэрээний шүүмжлэлт хандлага

Граф, Карл Хэнрик – (1815-1869) Германы Хуучин Гэрээний эрдэмтэн, *Хуучин Гэрээний Түүхэн Номууд* хэмээх номын зохиолч

Хенотейзм – Олон бурхан байдаг гэдгийг хүлээн зөвшөөрдөг ч нэг л бурханд өөрсдийгөө зориулдаг итгэл үнэмшил

натурализм – сүнслэг зүйлс байдаг ч бодит амьдралд нөлөө үзүүлдэггүй бөгөөд шинжлэх ухаанд байр суурь эзэлдэггүй гэдэг итгэл үнэмшил

натуралист түүхч үзэл – аливаа зүйлийг ойлгох хамгийн сайн арга зам бол эдгээр нь байгалийн жамаараа хэрхэн хөгжин өөрчлөгддөгийг ойлгох явдал юм гэдэг итгэл үнэмшил

Палео Еврей – Христээс өмнөх 1000-600 оны хооронд ашиглаж байсан Еврей хэлний хэлбэр

Пентатух – Хуучин Гэрээний эхний таван ном

Политейзм– Олон бурханд итгэх итгэл

Тахилчийн сурвалж ("П") – Эх сурвалжийн шүүмжлэлийн дагуу Пентатухт хамаатай утга зохиолын дөрөв дэх эх сурвалж. Хэсэг бүлэг тахилч нар (priests) ихэвчлэн бичсэн гэж үздэг тул “П” гэж нэрлэдэг

Прото- Еврей – Мосегийн үед ашиглаж байсан Канаан хэлний аялгатай нягт холбоотой Еврей хэлний эртний хэлбэр

найруулгын шүүмж – таамаг баримтуудыг хэрхэн хамтад нь нэгтгэн боловсруулж, өнөөгийн Библийг бий болгосон болохыг судалдаг Библийн шүүмжлэлт хандлага

Сизе айм либэн (*Sitz im Leben*) – “амьдралын нөхцөл байдал” эсвэл “соёлын нөхцөл” гэсэн утгатай герман үг

Эх сурвалжийн шүүмж – мөн утга зохиолын шүүмж гэж нэрлэдэг. Пентатухын зарим хэсэг нь бие даасан бичгийн эх сурвалжаас эхтэй гэж тайлбарладаг Хуучин Гэрээний эртний шүүмжлэлт хандлага

өмнөх ертөнц- Библийг бичээчдийн бичсэн дэлхий ертөнц

тэдний ертөнц – Бичвэрийн уншигчдын амьдарч байгаа цаг хугацаа, дэлхий ертөнц

Уламжлалын шүүмж – мөн уламжлалтүүхэн шүүмж гэж нэрлэдэг. Эртний аман уламжлалууд болон бичгийн эх сурвалжууд нь теологийн болон улс төрийн бүрэн цогц үзэл санаа болж хөгжсөнийг судалдаг Библийн шүүмжлэлт хандлага

Вэллхаусен, Жулиус – (1844-1918) Пентатухын талаарх таамаг баримт бичгүүдийг хөгжүүлсэн Германы теологич

Яавэ – Ихэвчлэн “ЭЗЭН” гэж орчуулагддаг, “Би бол Би байгаа” гэдэг хэлцээс гаралтай Бурханы Еврей нэр

Яавэ Элохим – “Эзэн Бурхан” гэсэн утгатай Еврей хэлц (галиг)

Яавэ Ирэ – “Эзэн хангадаг” гэсэн утгатай Еврей хэлц (галиг)

Яавист ("Ж") – Эх сурвалжийн шүүмжлэлийн дагуу Пентатухт хамаатай хамгийн эртний утга зохиолын эх сурвалж. Эдгээр хэсгүүдэд “Яавэ” гэдэг үг орсон бичгийн эх сурвалжууд байдаг учраас “Ж” гэж нэрлэсэн (Герман хэлэнд Яавэ гэдэг үг нь “Ж” үсгээр эхэлдэг)